



Save the Children

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА БАГШИЙН ЁС ЗҮЙ

СУРГАЛТЫН МОДУЛЬ

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА БАГШИЙН ЁС ЗҮЙ СУРГАЛТЫН МОДУЛЬ

Улаанбаатар хот
2025 он

Энд илэрхийлсэн үзэл санаа нь зөвхөн зохиогчдынх бөгөөд Хүүхдийг Ивээх Сангийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэхүү модуль сургалтын сургагч багшийн гарын авлага нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд боловсруулагдав.

© Save the Children 2025.

Боловсруулсан:

У.Пагма, Гүн Билиг Оюун ТББ

Х.Өлзийтүнгалаг, МУБИС, Нийгмийн ажил арга зүйн тэнхим

Ч.Должинсүрэн, ШУТИС, Нийгмийн ажлын тэнхим

Хянан тохиолдуулсан:

Ж.Батцэцэг, ХИС, төслийн зохицуулагч

Э.Оюунмаа, ХИС, Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтан

Ч.Мөнгөнтүяа, ХИС, Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтан

АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	6
Модулийн танилцуулга	8
Модулийн зохион байгуулалт	9
Модулийг хэрэглэх зөвлөмж	10
Модулийн ерөнхий бүтэц	13
Сургалтын хөтөлбөр	14

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ

15

Сэдэв 1.1 Багш мэргэжлийн дүр төрх, багш мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчмууд	17
Сэдэв 1.2 Багшийн ёс зүйн хэм хэмжээ	19
1.2.1 Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	22
1.2.2 Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	25
1.2.3 Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	28
1.2.4 Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ	33
Сэдэв 1.3 Ёс зүйн асуудал гарахад нөлөөлдөг хүчин зүйлс	36
Сэдэв 1.4 Ёс зүйн асуудлаас урьдчилан сэргийлэх арга зүй	39
4.1 Анхдагч урьдчилан сэргийлэлт	42
4.2 Хоёрдогч урьдчилан сэргийлэлт	51
4.3 Гуравдагч урьдчилан сэргийлэлт	60
Нэмж судлах материал	64

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДАЛД БАГШИЙН ҮҮРЭГ

65

Сэдэв 2.1 Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ	67
Сэдэв 2.2 Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж илрүүлэх арга	73
Сэдэв 2.3 Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл явц	78
Нэмж судлах материал	83

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны а/545 тушаал 1 дүгээр хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”

Хавсралт 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/545 тушаал 2 дугаар хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Багшийн хөгжил

Багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явц.

Багш мэргэжлийн үнэт зүйлс

Багшийн мэргэжлийг тодорхойлдог суурь зарчим, итгэл үнэмшил, үнэ цэнэ, ёс суртахууны хэм хэмжээг багтаадаг бөгөөд энэ нь суралцагчдын хөгжил, суралцах чадварыг дэмжих, шударга, тэгш харьцах, нийгмийн хариуцлагыг ухамсарлах зэрэг хандлагуудыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Багш мэргэжлийн ёс зүй

Багшийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн итгэл үнэмшил, хэвшсэн соёл, мэргэжлийн харилцааны хэв маяг, мөн хэрэгжүүлэх эс үйлдэх үйлдлийг багтаасан ойлголт юм.

Багш мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ

Багшийн мэргэжилдээ үнэнч байж, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалж, хүлээсэн үүргээ чанд биелүүлэх талаар тогтоосон шаардлагын цогц.

Багшийн ёс зүйн зөрчил

Тухайн дүрмээр тогтоосон багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Ёс зүйн дүрэм

Багш болон боловсролын байгууллагын ажилтнууд баримтлах мэргэжлийн ёс зүйн зарчим, хэм хэмжээг нэгтгэн тогтоосон баримт бичиг.

Ёс зүйн зөвлөл

Боловсролын байгууллагад багшийн ёс зүйн зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх, зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх зорилгоор ажилладаг бүтэц.

Ёс зүйн хоёрдмол байдал (дилемма)

Мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчим, хувь хүний үнэт зүйлсийн зөрчилт байдлын улмаас аль нэг сонголттой тулгарах нөхцөл байдал.

Ёс зүйн урхи

Багш мэргэжлийнхээ хүрээнд санаатай болон санаандгүйгээр ёс зүйн алдаа гаргах, эрх мэдлээ зохисгүй ашиглах, сурагчийн эрх ашгийг хохироох, мэдээллийн нууцлалыг зөрчих, эсвэл нийгмийн шахалт, хүлээлтэд автсанаар үнэнч, шударга бус шийдвэр гаргах зэрэг ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй нөхцөл байдал юм.

**Мэргэжлийн
хил хязгаар**

Багшийн мэргэжлийн хүрээнд баримтлах ёстой үүрэг, харилцааны хязгаар, сурагч болон эцэг эхтэй харилцахдаа мэргэжлийн ёс зүйд нийцүүлэн баримтлах дүрэм, зааг.

**Ёс зүйн шийдвэр
гаргалт**

Ёс зүйн асуудал үүсэхэд багшийн баримтлах арга зам, сонголт хийх үйл явц бөгөөд үнэт зүйл, хэм хэмжээ, эрх ашиг, шударга ёсны зарчимд тулгуурлана.

**Ёс зүйн урьдчилан
сэргийлэлт**

Багшийн мэргэжлийн үйл ажиллагаанд ёс зүйн зөрчил үүсэхээс сэргийлэх, багшийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, сургалт, зөвлөгөө, хяналт зэргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

**Хүүхдийн эрхийн
зөрчил**

Хүүхдийн хууль ёсны эрх, эрх чөлөөг хохироосон аливаа үйлдэл эсвэл эс үйлдэл (жишээ нь: боловсрол эзэмших эрхээ эдлэх боломжгүй болох, ялгаварлан гадуурхах).

Хүүхэд хамгаалал

Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах нөхөн сэргээх урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн тус хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээ.

**Хүүхдийн эсрэг
хүчирхийлэл**

Хүүхдийн хэвийн өсөлт хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц үл хайхрах, сэтгэл санаа, бие махбод, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүй.

Мэдээлэх механизм

Хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой зөрчил, хүчирхийллийн талаар мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллагад хүргэх албан ёсны систем, журам.

Суралцагч

Суралцагч Боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүнийг хэлнэ.

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Зорилго:

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаарх мэдлэг, ойлголт өгөх, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, аливаа асуудал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах Сургагч багшид зориулагдсан.

Энэхүү сургалтын модуль нь “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлагатай хамт ашиглагдана.

“Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага:

- Сургагч багшид энэ сэдвийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой онол, практик хосолсон мэдээлэл багтсан.
- Сургагч багш сургалтыг зохион байгуулахаас өмнө тус гарын авлагыг бүрэн гүйцэд уншиж судалсан байх шаардлагатай.

“Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын модуль:

- Таны одоо уншиж байгаа энэ материалд сургагч багш нарт зориулсан 2 бүлэг, 8 сэдэв бүхий 16 цагийн сургалтын алхамчилсан үйл ажиллагаа, сургалтын бүх хэрэглэгдэхүүнийг хамтад нь багтаасан.

МОДУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО



ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД



СУДЛАХ ЦАГ



АРГА ЗҮЙ



СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН



УНШИХ МАТЕРИАЛ



ХИЧЭЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ



ХАВСРАЛТ

МОДУЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

СУРГАГЧ БАГШ

- Сургалтыг явуулах сургагч багш нь хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, багшийн ёс зүйн чиглэлээр хичээл зааж байсан туршлагатай байх;
- Сургагч багш нь “Хүүхэд хамгаалал ба багшийн ёс зүй” сургалтын гарын авлагыг сайтар уншиж судлан, агуулгыг бүрэн ойлгосон байх;
- Сургалтын модуль нь гарын авлагын агуулга, үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулагдсан учраас үндсэн мэдээлэл, гүйцэтгэх дасгал даалгаврыг гарын авлагатай уялдуулан хэрэгжүүлэх;
- Сургагч багш нь сургалтын онол, заах арга зүй, насанд хүрэгчдийн суралцах арга барилыг мэддэг байх;
- Сургагч багш нь сэдвийг тайлбарлахдаа өөрийн туршлагыг хуваалцаж болох хэдий ч агуулга нь энэхүү модуль болон сургалтын гарын авлагад дурдсанаас зөрөхгүй байхад анхаарах;
- Сургалт эхлэхээс өмнө оролцогчдын дунд хүүхэд хамгааллын болон ёс зүйн зөрчил гаргаж, ямар нэг хэлбэрийн хариуцлага хүлээж байсан оролцогч байгаа эсэхийг судлах, тийм оролцогч байвал тухайн оролцогчдын гаргаж байсан зөрчилтэй ижил төстэй кейс, жишээ ярихаас зайлсхийж, өөр кейсүүд бэлтгэх;
- Сургагч багш нь хариуцлагатай байх, цаг баримтлах, ёс зүйн хувьд үлгэр жишээ байдлыг оролцогчдодоо үлгэрлэх;

СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ

- Сургалтыг 2 сургагч багш хамтдаа бэлтгэж, явуулах бөгөөд нэг нь сэдвийн үндсэн агуулгыг хөтөлж, нөгөө нь дэмжлэг үзүүлэх байдлаар хамтран ажиллана. Хоёр чиглүүлэгчийн хүйсийн тэнцвэрийг харгалзвал зохимжтой.
- Сургалтын агуулга нь хүүхдийн эрх, хамгаалал, багшийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хөндөх учир нэг сургуулийн багш нар юм уу, нэг аймаг, сумын гэх мэт хоорондоо танил 20 - 25 оролцогч хамруулахыг зөвлөж байна.
- Сургалтыг хоёр өдрийн хугацаатай төлөвлөсөн боловч орчин, оролцогчдын нөхцөл байдлаас хамаарч өдөр нэмж болно. Оролцогчид бүтэн өдрөөр юм уу, 2 өдөр дараалан сургалтад хамрагдах боломжгүй байвал сургалтыг хэсэгчлэн хувааж, 7 хоногт 1-2 удаа явуулж болно. Ингэснээр оролцогчид сурсан зүйлээ хэрэгжүүлж, дараагийн сургалт дээр туршлагаа хуваалцах боломжийг олгодог.
- Сургалт зохион байгуулах байр нь гэрэлтүүлэг сайтай, агаар чөлөөтэй нэвтрэх цонхтой, дэлгэц, самбар бүх оролцогчид чөлөөтэй харагдахуйц байрлалтай, бүлгээр ажиллах, дүрийн тоглолт хийх зай талбай сайтай, дуу чимээ бага, хэт хол биш, ирж очиход аюулгүй байх ба тусгай хэрэгцээтэй оролцогч орж гарахад саадгүй дэд бүтэцтэй байна

МОДУЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Модулийн бүлэг	Хичээл	Сэдэв	Цаг
ЕБС-ийн багшийн ёс зүйн асуудал (11 цаг)	Хичээл 1.	Багшийн мэргэжлийн дүр төрх, багш мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчим	1
	Хичээл 2.	Багш мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ	4
	Хичээл 3.	Ёс зүйн асуудлаас урьдчилан сэргийлэх арга зүй	6
Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн үүрэг (5 цаг)	Хичээл 4.	Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн дагаж мөрдөх хэм хэмжээ	1
	Хичээл 5.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх арга	2
	Хичээл 6.	Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл явц	2
Нийт цаг			16



Модулиар эзэмших мэдлэг, чадвар, хандлага:

- Хүүхдийн эрх, хамгааллын тухай хууль, бодлого, журмын хэрэгжилтийг хангах талаар үндсэн ойлголт, мэдлэг, ур чадвартай болно.
- Хүүхэд, эцэг эх, хамт олон, хамтрагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, технологийг хариуцлагатай ашиглах талаар мэдлэг ойлголтоо бататгаж, мэргэжлийн хил хязгаарыг баримтлан ажиллах арга зүйд суралцана.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, илрүүлэх, мэдээлэх механизмын талаар ойлголттой болж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйд суралцана.
- Ёс зүйн асуудлаас урьдчилан сэргийлэх ойлголттой болж, практикт хэрэглэх чадварт суралцана.



Арга зүй:

- Лекц
- Ярилцлага
- Кейс анализ
- Хэлэлцүүлэг
- Бүлгээр ажиллах



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Зөөврийн компьютер, проектор
- Сургалтын явцад хэрэглэх дасгал, даалгавар, кейсүүд
- Цагаан самбар, дэлгэц цаас
- Наадаг өнгийн цаас
- Маркер, өнгийн харандаа
- Тараах материал

“ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ БАГШИЙН ЁС ЗҮЙ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Сургалтын зорилго

- Ерөнхий боловсролын сургуулийн багш нар хүүхдийн эрх, хамгаалал, ёс зүйн талаар ойлголт мэдлэгээ бататгаж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх, багшийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах, аливаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүйд суралцана.



Сургалтын хүрэх үр дүн

- Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтоо нэмэгдүүлнэ.
- Багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар, ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлнэ.
- Багшийн мэргэжлийн ёс зүйн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон сургуулийн орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх арга зүйд суралцана.



Сургалтын үргэлжлэх хугацаа

- 16 цаг



Сургалтын хамрах хүрээ:

- Сургуулийн өмнөх боловсролын багш нар
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нар
- Насан туршийн боловсролын төвийн багш нар
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нар
- Сургалтын төвийн багш нар

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ЦАГ	ӨДӨР 1	ӨДӨР 2
08.00 - 08.30	Бүртгэл	Бүртгэл
08.30 - 08.40	☐ Сургалтын нээлт	☐ Өмнөх өдрийн сургалтыг сэргээн санах
08.40 - 09.00	☐ Сургалтын өмнөх сорил	
09.00 - 09.45	☐ Багш мэргэжлийн дүр төрх, үнэт зүйлс, ёс зүйн зарчмууд	☐ Хоёрдогч урьдчилан сэргийлэлт
09.45 - 10.30	☐ Багшийн ёс зүйн хэм хэмжээ-Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	☐ Гуравдагч урьдчилан сэргийлэлт
10.30 - 10.45 БАГА ҮДИЙН ЗАВСАРЛАГА		
10.45 - 11.30	☐ Багшийн ёс зүйн хэм хэмжээ-Ажил мэргэжлийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	☐ Гуравдагч урьдчилан сэргийлэлт /үргэлжлэл/
11.30 - 12.15	☐ Багшийн ёс зүйн хэм хэмжээ-Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	☐ Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ
12.15 - 13.15 ҮДИЙН ЗАВСАРЛАГА		
13.15 - 14:00	☐ Багшийн ёс зүйн хэм хэмжээ-Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах ёс зүйн хэм хэмжээ	☐ Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх арга
14.00 - 14:45	☐ Ёс зүйн асуудал гарахад нөлөөлдөг хүчин	
14.45 - 15:30	☐ Ёс зүйн асуудлаас урьдчилан сэргийлэх арга зүй	☐ Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл явц
15.30 - 15.45 ИХ ҮДИЙН ЗАВСАРЛАГА		
15.45 - 17.15	☐ Анхдагч урьдчилан сэргийлэлт	☐ Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл явц /үргэлжлэл/
17.15 - 17.30	☐ Тухайн өдрийн хичээлийг дүгнэх, хаах	☐ Сургалтын дараах сорил ☐ Сургалтыг дүгнэж хаах

модуль 1

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ

	Агуулга	Судлах цаг
	Нийт судлах цаг	11
01	Багш мэргэжлийн дүр төрх, багш мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчмууд	1
02	Багшийн ёс зүйн хэм хэмжээ	4
03	Ёс зүйн асуудлаас урьдчилан сэргийлэх арга зүй	6

Бүлэг сэдвийн зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн талаарх үндсэн ойлголт өгч, ёс зүйн хэм хэмжээг сургалтын үйл ажиллагаанд мөрдөх, ёс зүйн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зүйд суралцах

Хүрэх үр дүн

- Багшийн мэргэжлийн онцлог, үнэт зүйлс, ёс зүйн зарчмыг танин мэдэж, өөрийн ажил мэргэжлийн харилцаанд тусган хэрэгжүүлэхийн ач холбогдлыг ойлгоно.
- Ёс зүйн хэм хэмжээг суралцагч, эцэг эх, хамт олон, олон нийтийн өмнө дагаж мөрдөх талаар ойлголт өгч, хандлага төлөвшүүлнэ.
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн хил хязгаарыг баримтлах, зөв шийдвэр гаргах, хариу арга хэмжээ авах чадвартай болно.
- Мэргэжлийн үйл ажиллагааг ёс зүйн зарчим, үнэт зүйлсэд нийцэж байгаа эсэхэд өөрийгөө үнэлэх, хөгжүүлэх арга зүйд суралцана.



БАГШ МЭРГЭЖЛИЙН ДҮР ТӨРХ, БАГШ МЭРГЭЖЛИЙН ҮНЭТ ЗҮЙЛС, ЁС ЗҮЙН ЗАРЧМУУД



Хичээлийн зорилго:

Багшийн мэргэжлийн онцлог, үүрэг хариуцлага, мэргэжлийн үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээний талаар ойлголттой болж, өөрийн мэргэжлийн үнэт зүйлсийг тодорхойлох чадварт суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Багш мэргэжил
- Багшийн мэдлэг, чадвар
- Багшийн үүрэг хариуцлага
- Багшийн мэргэжлийн үнэт зүйлс
- Багшийн мэргэжлийн ёс зүй
- Багш мэргэжлийн ёс зүйн зарчмууд



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Танилцах хэсэг	15 минут
2	Үйл ажиллагаа 2. Сургалтын танилцуулга	10 минут
3	Үйл ажиллагаа 3. Үндсэн хэсэг	15 минут
4	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт хэсэг	5 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Сэдвийн танилцуулга, илтгэл
- Жижиг багаар ажиллах
- Асуулт хариулт, харилцан ярилцах



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Нэрийн хуудасны цаас-хүний тоогоор
- Бал
- РРТ танилцуулга



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 13-14 дугаар хуудас



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Танилцах дасгал - 15 минут

Оролцогчдоос тойрон зогсохыг хүснэ. Тэднийг сургалтад оролцож байгаад нь талархлаа илэрхийлээд, Сургагч багш өөрийн нэр, ажил, албан тушаалаа танилцуулна.

Дараа нь оролцогчид хоорондоо танилцах тоглоом тоглох гэж байгааг хэлээд, “Энэ тоглоомыг тоглохдоо цаас ашиглана” хэмээн оролцогч бүрт жижиг нэрийн хуудасны хэмжээтэй цаас тараана. Тэд нэрийн хуудас дээр нэр, ажил, сонирхдог зүйлээ бичиж, бэлдсэн хайрцагт хийх ба Сургагч багш бүгдийг нь холих юм. Дараа нь хүн бүр хайрцагнаас нэг нэрийн хуудас авч, эзэнтэй нь танилцаж, эргээд түүнийг бусдадаа танилцуулна. Бүх оролцогчийг танилцуулга хийж дууссаны дараа Сургагч багш талархсанаа илэрхийлээд, суудалдаа суухыг урина.

Үйл ажиллагаа 2: Сургалтын танилцуулга – 10 минут

Сургагч багш энэхүү 2 өдрийн сургалтын зорилго, хөтөлбөр, онцлог, хүрэх үр дүнгийн талаар танилцуулга хийж, оролцогчдын сургалтаас хүлээж буй хүлээлтийн талаар сонсоно. Дараа нь ангийн дүрэм гаргана. Дүрэм гаргахдаа Сургагч багшид зориулсан тэмдэглэл хэсэгт дурдсан зүйлсийг сайтар анхаарна.

Үйл ажиллагаа 3: Үндсэн мэдээлэл – 15 минут

Багшийн мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчмуудын талаарх үндсэн ойлголтыг урьдчилан бэлтгэсэн РРТ ашиглан танилцуулна.

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт - 5 минут

Сургагч багш сэдвийг дүгнэхдээ багш мэргэжлийн онцлог, мэргэжлийн мэдлэг, үр чадвар, үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээг өдөр тутмын сурган хүмүүжүүлэх үйл явцдаа мөрдлөг болгон ажиллах ёстойг сануулахын зэрэгцээ мэргэжлээрээ бахархах үзлийг нь дэмжиж, урамшуулна.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Хичээлийн зорилго:

Багшийн мэргэжлийн ёс зүйн суурь зарчим, үнэт зүйлс болон суралцагч, хамт олон, эцэг эх, ажил мэргэжлийн өмнө хүлээх хэм хэмжээний ойлголт өгөх, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлнэ.



Үндсэн ойлголтууд:

- Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ



Хичээлийн үйл явц:

	Үйл ажиллагаа	Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал хэсэг	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	40 минут
3	Үйл ажиллагаа 3. Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	45 минут
4	Үйл ажиллагаа 4. Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ	45 минут
5	Үйл ажиллагаа 5. Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ	30 минут
6	Дүгнэлт хэсэг	15 минут
	Нийт	180 минут (4 цаг)



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер
- Тараах материал.
- Хавсралт 1. Карт-хүний тоогоор



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 15-27 дугаар хуудас



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Багт хуваагдах – 5 минут

1. Оролцогчдын тооноос хамаарч үнэт зүйлийн 4-6 багт хуваарилахын тулд 4-6 төрлийн карт (Хариуцлага, Шударга байдал, Нууцлал, Хүндлэл, Үнэнч байдал, Хамтын ажиллагаа) сонгуулж, ижил карт сонгосон оролцогчид нэг баг болно.
2. Сургагч багш нь дараах 4 ёс зүйн хэм хэмжээний талаар дэлгэрүүлэн ярилцана гэж хэлээд хичээлээ үргэлжлүүлнэ.
 - I. Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
 - II. Ажил, мэргэжлийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
 - III. Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
 - IV. Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ

1. Материал бэлтгэх

- Өнгөт принтер, А4 хэмжээтэй цаас (хүнд/зөөлөн аль аль нь боломжтой).
- Хайч, цавуу

2. Файл бэлтгэх

- А4 хуудсанд картны байрлалыг 2 багана × 4 мөр (нэг хуудсанд 8 карт) тохируулна.
- Карт бүрт үнэт зүйлсийн нэр + модуль бичсэн байна.
- Өнгө бүр үнэт зүйлсээр ялгагдсан байна.

3. Хэвлэх

- Өнгөт принтерээр хэвлэнэ.
- Хэрэв картны бат бөх чанар хэрэгтэй бол нимгэн картон цаас ашиглаж болно.

4. Сонгуулахад бэлтгэх

- Картуудыг үнэт зүйлсээр нь тусад нь холино.
- Оролцогч бүр нэг карт сонгож авна.
- Ижил үнэт зүйл сонгосон оролцогчид нэг багт хуваарилагдана.
- Сонгосон үнэт зүйлсийн дагуу багийг хуваарилж, үйл ажиллагаа эхэлнэ.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Сургагч багш нь сургалтыг зохион байгуулахын өмнө мэргэжлийн ёс зүйн дүрэм, ёс зүйн хэм хэмжээний шаардлагыг бүрэн уншиж танилцсан байх ба энэ сэдэв нь эмзэг асуудлыг хөнддөг учраас анхааралтай хөтлөн явуулах шаардлагатайг сайтар санана.

Сургалтын үеэр оролцогч бүр өөрийн үзэл бодол, мэдрэмжээ чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх нь чухал. Иймээс ангийн дүрэмдээ сургалтын явцад яригдсан зүйлсийн нууцыг чанд хадгалах, хувь хүн болон байгууллагын нэр зааж ярихгүй байх гэдгийг тусгаж, дагаж мөрдөхийг оролцогчдод байнга сануулж, дүрмийн заалтуудыг чанд баримтална. Мөн эмзэг кейс, жишээг зөвхөн ерөнхий бөгөөд оноосон нэргүй тайлбарлаж, оролцогч өөрөө хүссэн үед санал бодлоо хуваалцах боломжийг олгож, асуултад хүчээр татан оруулахгүй байхад анхаарна. Сэтгэл хөдлөлөө илэрхийлж буй оролцогчдыг хошигнох, үл хүндэтгэх байдал үзүүлэхгүй бөгөөд анхааралтай сонсож, эерэгээр дэмжих үгийг хэрэглэнэ.

Сургалтын агуулгыг заахдаа хувийн байр сууриа илэрхийлэх бус, мэргэжлийн баримт бичиг, судалгааг түшиглэх, асуулт, саналыг хүндэтгэлтэй сонсож, “буруу, зөв” гэх хатуу дүгнэлт өгөхөөс зайлсхийх хэрэгтэй. Хичээлийн төгсгөлийг эерэг өнгө аястайгаар дүгнэлт хийснээр сургалтын үр дүн нэмэгдэх болно.



СУРАЛЦАГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Үндсэн ойлголтууд:

- Суралцагчидтай харилцаж ажиллахдаа мөрдөх ёс зүйн зарчмууд
- Нийтлэг гардаг ёс зүйн зөрчлүүд
- Суралцагчид үзүүлэх сөрөг нөлөө
- Багшид үзүүлэх сөрөг нөлөө
- Суралцагчтай харилцах мэргэжлийн хил хязгаар



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 2.1 Удиртгал хэсэг	5 минут
2	Үйл ажиллагаа 2.2 Үндсэн хэсэг	15 минут
3	Үйл ажиллагаа 2.3 Багаар ажиллах	20 минут
4	Үйл ажиллагаа 2.4 Хичээлийн дүгнэлт	10 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Лекц (Үндсэн ойлголтуудыг тайлбарлах)
- Ярилцлага, хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)
- Кейс дээр ажиллаж, дадлага хийх



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер
- Тараах материал
- Хавсралт 1. Кейсүүд- тус бүр 2ш



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 5 минут

Сургагч багш нь оролцогчдод багшийн ёс зүйн хэм хэмжээ гэсэн агуулга эхэлж байгааг анхааруулан хэлээд, Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-д заасан ёс зүйн 4 хэм хэмжээ болох

Нэг. Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;

Хоёр. Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;

Гурав. Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;

Дөрөв. Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ сэдвүүдийн талаар ярилцана. Одоо “Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ” сэдэв эхэлж байна гэдгийг сануулан хэлээд цааш үргэлжлүүлнэ.

Үйл ажиллагаа 2: Хэлэлцүүлэг ба бүлгийн ажил - 20 минут

Сургагч багш нь багуудад хавсралтад байгаа 4 кейсийг хуваарилж

- Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ хэрхэн хөндөгдөж байна вэ?
- Энэ нөхцөл байдал үргэлжилсээр байвал суралцагч болон багшид өөрт нь ямар сөрөг үр дагавар гарах вэ?

Багууд ажиллаж дууссаны дараа бие биедээ богино танилцуулга хийнэ.

Үйл ажиллагаа 3: Мэдээлэл өгөх - 15 минут

Сургагч багш урьдчилан бэлтгэсэн PPT ашиглан “Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ”-ний тухай үндсэн мэдээллийг өгч, асуултад хариулна.

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт - 5 минут

Оролцогч бүр өөрийн багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нэг алхмыг бичиж, 2-3 оролцогч сайн дурын үндсэн дээр бусдадаа хуваалцах байдлаар сэдвийг дүгнэнэ.

Кейс 1:

“Манай түүхийн эмэгтэй багш хүүхдүүдийг гадна төрхөөр нь маш их доромжилдог. Охидыг “Биеэ үнэлэгч шиг хувцаслалаа” гэнэ. Хөвгүүдийг ч бас их доромжилно. Саяхан хөвгүүдийн дунд үсээ голоор нь хагалж самнадаг загвар болж байсан юм. Тэгсэн нэг хүүхдийг “Энэ үсийг нь хар даа. Буудуулж үхсэн элээний далавч шиг” гэж хэлээд бүх хүүхэд инээлдсэн. Анги дүүрэн хүүхдүүдэд нэгэн зэрэг шоолуулах тэр хүүхдүүд ямар байсан бол?”

Кейс 2:

Манай багш ангид байхдаа их ууртай, чанга хашгираад, бид нарыг загнаад, цохиод байдаг байж, аав ээжүүдийг харахаараа шал өөр болчихдог. Инээгээд л, сайхан аашлаад л, хүүхдүүдийг магтаад л. Хэзээ тийм байсан юм. Багшийг тийм зан гаргахаар сонин санагдаад байдаг.

Кейс 3:

3 дугаар ангийн охин маань нэг өдөр “Би Х-тэй нэг ширээнд суумааргүй байна.

Тэр хулгайч юм байна. Эртээд багшийн ширээн дээр байсан мөнгийг хулгайлаад сургуулийн цайны газраас пирожки авч идсэн байсан. Тэр юу ч биш. Эмээгийнхээ цүнхнээс мөнгө хулгайлж байсан гэж өнөөдөр багш бид нарт хэлсэн” гэсээр сургуулиасаа ирэв.

Ангийн багш нь дөнгөж сургууль төгсөж ирсэн залуу багш байсан юм. Тухайн үед би охиндоо “Х найзыгаа чи хулгайч гэж болохгүй. Тэр гэмшиж байгаа байх. Түүнийг “хулгайч” гэж битгий шоолоорой” гэж хэлсэн. Туршлагагүй залуу багш Х-г хашраах санаатай ангийнхандаа ингэж хэлсэн байх. Гэхдээ хүүтэй ганцаарчилж ярилцахгүй, бүх зүйлийг ангид задалсанд харамссан. Шинэ залуу багш нарт ийм эмзэг асуудалд мэдрэмжтэй хандаж, нууцыг хадгалах, хүүхдийнхээ нэр төрийг хамгаалах байдлаар хүүхэдтэй ажилладаг арга барилыг зааж сургаасай.

Кейс 4:

Манай ангийн багш эрэгтэй хүүхдүүдэд их сайн. Ялангуяа хамгийн сахилгагүй, байнга үймүүлдэг хүүхдүүдэд бүр юу ч хэлдэггүй. Тэр хүүхдүүд нь одоо бүр давраад бид нарын юмыг булаах, анги завааруулах зэрэг нь хэрээс хэтэрч байгаа. Охидууд багшид хэлэхээр “За яахав дээ, хөвгүүд чинь цагаа тулахаар та нарыг хамгаалах үүрэгтэй хүмүүс шүү дээ” гэж хэлдэг. Багш өөрөө 3 охинтой болохоор эрэгтэй хүүхдэд илүү сайн гэж өөр багшид ярьж байхыг нь би сонсож байсан. Гэхдээ тийм байсан ч гэсэн тэдэнд юу ч хэлэхгүй байх нь шударга биш гэж бодож байна.



АЖИЛ, МЭРГЭЖЛИЙНХЭЭ ӨМНӨ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Үндсэн ойлголтууд:

- Ажил мэргэжлийнхээ өмнө ёс зүйн хэм хэмжээ, зарчмууд
- Нийтлэг гардаг зөрчлүүд
- Ажил мэргэжлийн хил хязгаарыг баримтлах



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал хэсэг	10 минут
2	Үйл ажиллагаа 2. Бүлгийн ажил	20 минут
3	Үйл ажиллагаа 3. Мэдээлэл өгөх	10 минут
4	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт хэсэг	5 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Лекц (Үндсэн ойлголтуудыг тайлбарлах)
- Ярилцлага, хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер
- Тараах материал
- Хавсралт 1. Кейсүүд- тус бүр 2ш
- Хавсралт 2. Дүрэм боловсруулах загвар, багийн тоогоор



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 10 минут

Сургагч багш “Ажил мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ” сэдэв рүү шилжиж байгааг сануулан хэлээд оролцогчдоос дараах асуултуудыг асууж, хариултуудыг самбарт бичиж тэмдэглэнэ.

1. Багшийн мэргэжлийн нэр хүндийг хадгалахын тулд ямар зарчмыг баримтлах ёстой вэ?
2. Мэргэжлийн нэр хүндийг хадгалах нь багшийн өдөр тутмын ажилд ямар ач холбогдолтой вэ?
3. Хариуцлагатай байдал нь мэргэжлийн ёс зүйтэй хэрхэн холбогддог вэ?

Үйл ажиллагаа 2: Бүлгийн ажил - 20 минут

Багуудад Хавсралт 1-д буй кейсүүдийг хуваарилах ба Хавсралт 2-т буй “Ажил мэргэжлийн өмнө хүлээх ёс зүйн дүрэм боловсруулах загвар”-ыг мөн баг бүрд нэгийг тараан өгнө.

Сургагч багш багуудад гүйцэтгэх ажлын зөвлөмжийг танилцуулна.

- Багийн гишүүд өөрсдийгөө сургуулийн багш нарын зөвлөлийн гишүүн гэж төсөөлнө.
- Ямар дүрэм боловсруулж мөрдсөнөөр эдгээр кейсүүдэд гарч буй үйлдлүүдийг таслан зогсоож болох вэ? гэдгийг бодож, дүрмийн заалтуудыг шинээр боловсруулна.
- Тэдгээр заалтууд нь сургуулийн өдөр тутмын амьдралд хэрэгжих боломжтой, ойлгомжтой, уян хатан байх ёстой.
- Багууд өөрсдийн боловсруулсан дүрмээ бусдадаа танилцуулна.

Хамгийн уян хатан, хэрэгжүүлэх боломжтой, шинэлэг дүрэм боловсруулсан багийн ажил дээр хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Үйл ажиллагаа 3: Мэдээлэл өгөх - 10 минут

Сургагч багш урьдчилан бэлтгэсэн PPT ашиглан “Ажил мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ”-ний тухай үндсэн мэдээллийг өгч, асуултад хариулна.

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт - 5 минут

Сургагч багш “Багш нь зөвхөн хүүхдүүдийн өмнө төдийгүй, өөрийн ажил мэргэжлийнхээ өмнө ёс зүйн хариуцлага хүлээдэг гэдгийг онцлоод, ёс зүйн хэм хэмжээг баримтлах нь мэргэжлийн нэр хүндийг хамгаалж, боловсролын байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Та бүхний боловсруулсан дүрэм, санал нь зөвхөн хичээлийн даалгавар биш, харин сургуулийн орчинд бодитоор хэрэгжиж болох санаа юм. Хамгийн оновчтой дүрмүүд нь үргэлж ашиглагдах боломжтой” гэдгийг хэлээд дараагийн сэдэв рүү шилжиж байгааг анхааруулна.

Хавсралт 1.

№	Кейс	Хөндөгдсөн зарчим
1	“Би одоо 7 дугаар анги. Манай англи хэлний багш зарим үгнүүдийг буруу дууддаг, дүрэм заахдаа ч зөндөө алддаг. Би 3 жил англи хэлний сургалтад явж байгаа болохоор буруу хэлэхээр нь засаад хэлчихдэг юм. Тэрнээс болсон байх, багш надад дургүй болчихсон. Манай ангийн хүүхдүүд ихэнх нь англи хэлний хичээлээ надаас асуудаг, бас хуулдаг.”	- Тасралтгүй хөгжих - Мэргэжлийн нэр хүндээ хамгаалах - Хариуцлагатай байх
2	“Манай хүүхдийн ангийн багш нь фэйсбүүкт их идэвхтэй байдаг. Баяр болгоноор янз бүрийн гоё цэцэг, бэлэгний зураг тавиад “Тэрэндээ баярлалаа. Энэ шавьдаа баярлалаа” гэж бичсэн байдаг юм. Би эхэндээ анзаардаггүй байсан. Гэтэл хүүхэд маань баяр болохоор “Багшдаа бэлэг өгмөөр байна” гэдэг болсон. “Багш нарын баяраар өгсөн шүү дээ” гэхээр “Манай ангийнхан өгөөд би л өгөхгүй байна” гээд уурлаад байдаг. Тэгээд багшийнх нь тэр постууд хүүхдүүдэд “Багшид заавал бэлэг өгөх ёстой юм байна” гэдэг ойлголт төрүүлдэг байж магадгүй юм байна гэж бодсон. Багшийг нь “Та бэлэгний зураг постлохоо болино уу.” гэж хэлэлтэй биш. Одоо баяр болгоноор ямар нэг бэлэг авч өгөөд л явуулдаг болсон доо. Манай Монголын баяр хичнээн олон билээ дээ.”	- Мэргэжлийн нэр хүндээ хамгаалах - Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
3	“Зарим багш өөрийгөө бүх зүйлийг мэддэг болсон, хангалттай туршлагатай гэж боддог. Тиймээс багш нарт зориулсан чадавч бэхжүүлэх, шинэлэг арга зүй танилцуулах сургалтуудад хамрагддаггүй. Сургалтад суусан ч “мэддэг зүйл зааж цаг үрлээ” гэж шүүмжилдэг. Тухайн арга зүйг ажилдаа ашигладаггүй. Гэтэл сурагчдын зүгээс тухайн багшийг “хоцрогдсон, хуучирсан зүйл ярьдаг” гэж шүүмжилдэг. Харамсалтай нь тухайн багш үүнийг мэддэггүй, мэдсэн ч хүлээн зөвшөөрч, өөрийгөө хөгжүүлэхийг хүсдэггүй.”	- Тасралтгүй хөгжих - Үнэнч, шударга байх - Мэргэжлийн нэр хүндээ хамгаалах - Хариуцлагатай байх
4	“Манай монгол хэлний багш юм асуухаар тэрийгээ тайлбарлах гэж байгаад шал өөр зүйл яриад явчихдаг. Нэг ам нь халчих юм бол хичээлээ заахгүй өөр юм яриад л байдаг. Өөрийнхөө амьдралыг бас их ярьдаг. Анх бид нарт тэр нь сонирхолтой санагддаг байсан ч яваандаа залхаж эхэлсэн. Одоо бол “Багшаас битгий юм асуугаарай” гэж бие биедээ хэлдэг. Хичээлийн хамаг цагийг хэрэггүй юм ярьж өнгөрүүлэх нь хайран санагддаг болсон. Бид нар дараа жил төгсөхдөө монгол хэлээр ЭЕШ өгнө. Гэтэл багш хичээлийн цагийг ингэс тэгэс хийгээд өнгөрүүлэх гээд байх юм. Өөр ангид ингэдэг эсэхийг мэдэхгүй.”	- Тасралтгүй хөгжих - Мэргэжлийн нэр хүндээ хамгаалах - Хариуцлагатай байх

“Ажил мэргэжлийн өмнө хүлээх ёс зүйн дүрэм боловсруулах загвар”

Багийн нэр: _____

Шинэ дүрэм боловсруулах хүснэгт

	Дүрмийн заалт	Энэ дүрэм яагаад чухал вэ?	Ямар зөрчлийг энэ дүрмээр зохицуулах боломжтой вэ?

Баг бүр дүрмээ боловсруулсны дараа энд товч тайлбар бичнэ. (Тайлбар хэсэгтээ “яагаад энэ дүрэм чухал вэ?”, “ямар зөрчилд хэрэглэх боломжтой вэ?” гэдгийг сургуулийн өдөр тутмын амьдралд хэрэгжихүйц, ойлгомжтой, уян хатан байдлаар бичнэ)



ХАМТ ОЛОН, ХАМТРАН АЖИЛЛАГЧ, ОЛОН НИЙТИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Үндсэн ойлголтууд:

- Хамт олны өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Хамтран ажиллагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
- Ёс зүйн зөрчил ба үр дагавар



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 4.1 Удиртгал хэсэг	5 минут
2	Үйл ажиллагаа 4.2 Үндсэн хэсэг	15 минут
3	Үйл ажиллагаа 4.3 Багийн ажил	20 минут
4	Үйл ажиллагаа 4.4 Дүгнэлт хэсэг	5 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Лекц (Үндсэн ойлголтуудыг тайлбарлах)
- Ярилцлага, хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Бал
- Маркер
- А4 цаас – оролцогчийн тоогоор
- Тараах материал
- Хавсралт 1. Кейсүүд- тус бүр 2ш
- Хавсралт 2. “Хамт олон, хамтран ажиллагч, олон нийттэй харилцах харилцаанд баримтлах мэргэжлийн хил хязгаар” хүснэгт



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 5 минут

Сургагч багш “Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ” сэдэв рүү шилжиж байгаа бөгөөд энэ сэдэв нь хамт олон-хамтран ажиллагч-олон нийт гэсэн 3 том агуулгыг багтаана гэдгийг оролцогчдод анхааруулж хэлнэ. Дараа нь РРТ дээр эдгээр 3 ойлголтын ялгааг харуулна.

Үйл ажиллагаа 2. Хэлэлцүүлэг-15 минут

Оролцогч бүрт нэг ширхэг А4 цаас тараан өгч, голоор нь босоо шугам татаж, 2 хэсэг хуваагаад, доорх зааврын дагуу тус бүрд нь 3-5 зүйл бичихийг хүснэ.

- Зүүн гар талд нь “Би хамт ажилладаг хүнийхээ ямар үйлдэлд таагүй ханддаг вэ?”
- Баруун гар талд нь “Би хамт ажилладаг хүнийхээ ямар үйлдэлд дуртай вэ?”

Жишээлбэл, таагүй зүйлс: багаар ажиллахад бусдыгаа сонсдоггүй, өөрийнхөөрөө зүтгэдэг, хов ярьж, бусдыг муу хэлдэг..., таатай зүйлс: хамтарч ажиллахад найдвартай, хэлсэндээ хүрдэг, цаг хугацаандаа хийнэ гэсэн зүйлээ яг таг хийдэг. ...гэх мэт.

Бүх оролцогч бичиж дууссаны дараа дэргэдэх хүндээ өөрийн бичсэн зүйлсээ танилцуулж, хос хосоороо ярилцана. Эцэст нь 3 хосын бичсэн зүйлийн талаар сонсож, ярилцаад дараагийн хэсэг рүү шилжинэ.

Үйл ажиллагаа 3: Хэлэлцүүлэг – 15 минут

Багуудад Хавсралт 1 дэх кейсүүдийг тараан өгч, доорх сэдвүүдийн дагуу ярилцах даалгавар өгнө.

- Хамт олонтой харилцах харилцаанд ёс зүйн Баримтлах болон Хориглох зүйлс
- Хамтран ажиллагчтай харилцах харилцаанд ёс зүйн Баримтлах болон Хориглох зүйлс
- Олон нийт, тэр дундаа эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаанд ёс зүйн Баримтлах болон Хориглох зүйлсийг бичих даалгавар өгнө.

Багууд ажиллаж дууссаны дараа бусад багтай хуваалцах ба ижил сэдэв авсан 2 баг эхний баг нь танилцуулж дуусахад нөгөө баг нь давхардаагүй үлдсэн санаагаа нэмж хэлэх байдлаар үргэлжлүүлнэ.

Сургагч багш Хавсралт 2 дахь “Хамт олон, хамтран ажиллагч, олон нийттэй харилцах харилцаанд баримтлах мэргэжлийн хил хязгаар” хүснэгтийг оролцогч бүрд тараан өгнө.

Үйл ажиллагаа 4: Мэдээлэл өгөх - 10 минут

Сургагч багш урьдчилан бэлтгэсэн РРТ ашиглан “Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ”-ний тухай үндсэн мэдээллийг өгч, асуултад хариулна.

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт - 5 минут

Оролцогчдоос хажууд суугаа хүнтэйгээ хичээлийн агуулга болон дасгал ажлаас хамгийн сайн ойлгосон хоёр зүйлээ хуваалцахыг хүсээд, “Багшийн ёс зүйн үлгэр дуурайл зөвхөн анги дотор бус, хамт олон, эцэг эх, олон нийтийн өмнө бий болдог. Та бүхний өдөр тутмын харилцаа бол багшийн мэргэжлийн нэр хүндийг тодорхойлогч гол хүчин зүйл юм” гэж сэдвийг дүгнэн, дараагийн сэдэв рүү шилжиж байгааг оролцогчдод дуулгана.

Хавсралт 1.

№	Кейс	Хөндөгдсөн зарчим
1	“Би сошиал дээр хүүхдийн хөгжил, хүмүүжлийн талаар маш хэрэгтэй мэдээлэл тавьсан нэг багшийг дагадаг болсон юм. Профайл нь ... багш гэсэн нэртэй. Удалгүй эргээд дагахаа больсон. Учир нь янз бүрийн шар мэдээг ямар ч шүүлтүүргүй шэйрлэдэг, бусдыг байнга шүүмжилдэг (бүтээлч шүүмжлэл биш) болохыг нь мэдээд “Иймэрхүү мэдээний эх сурвалжийг шалгадаггүй багш байна гэж үү” гэж бодсон. Бас аливаад маш сөрөг ханддаг, тэрнийгээ илэрхийлж байгаа хэв маяг нь таагүй санагдаж, түүгээр хичээл заалгадаг хүүхдүүдэд санаа зовсон.”	• Мэргэжлийн дүр төрхөө хадгалах • Зөрчилдөөнөөс ангид байх
2	Би багш болоод 2 жил гаран болж байна. Манай сургуульд олон жил ажилласан туршлагатай сайн багш нар цөөнгүй бий. Гэхдээ зарим нэг багш өөрийгөө “хамгийн сайн нь” гэж боддог юм билээ. Заах аргын нэгдэл дээр санал хэлэх юм уу, шинэлэг арга зүй ярихаар “Энэ манайд тохирохгүй, өмнө нь зөндөө үзсэн. Чи сайн мэдэхгүй байна” гээд шууд үгүйсгэдэг. Тэгээд хичээлээ заагаад нэг их харьцахгүй байхаар их дургүй. Юм болвол өөнтөглөөд, шүүмжлээд байдаг. Өөрт нь тал засаад, өөрийг нь магтаад, байнга юм асуугаад яваад байвал маш сайхан зантай байдаг. Гэхдээ л ардуур “ажлаа мэддэггүй, би зааж өгдөг” гэх мэтээр муу хэлдэг юм билээ. Ажлын ачааллаас илүү иймэрхүү хандлагатай хүмүүстэй хамтарч ажиллах нь хамгийн их ядраадаг даа.	• Харилцан хүндлэх • Зөрчилдөөнөөс ангид байх • Ялгаварлахгүй байх • Үлгэр дуурайлтай байх
3	Би сургуулийнхаа эцэг эхийн зөвлөлийн гишүүн. Өнгөрсөн жил манай зөвлөл санаачлан сургуулийн хэмжээнд хүүхдийн хөгжлийг дэмжих компаниаг ажил маш амжилттай зохион байгуулсан. Манай зөвлөлтэй хамтарч ажиллах үүрэгтэй 2 багш байсан юм. Нэг нь маш хариуцлагатай, нямбай, бүтээлч багш байсан тул биднийг үнэхээр сайн дэмжсэн. Харин нөгөө багш нь ямар нэг шалтаг хэлээд уулзалтад ирдэггүй, бэлтгэл ажилд ч нэг их оролцоогүй. Гэтэл яг компаниаг ажлын нээлт, хаалт дээр тайзан дээр гарч ирээд өөрөө бүхнийг санаачилж хийсэн мэт дүр эсгэж, бүх танилцуулгыг бидний өмнүүр орж хийсэн. Үнэхээр шударга бус санагдсан. Нөгөө багш маань даруухан зантай учраас энэ талаар хэл ам хийгээгүй. Гэхдээ багш хүмүүс ийм зальтай байж болохгүй гэж бодож байна.	• Хариуцлагатай хамтрагч байх • шударга байх

БОЛНО	БОЛОХГҮЙ
Хамт олонтой харилцах харилцаа	
Мэргэжил нэгт нөхдийнхөө шинэ санаачилгыг дэмжих, гаргасан амжилт, бүтээлч санаачилга, хийсэн ажил хөдөлмөрийг сайшаах, урам өгөх бөгөөд арга туршлагаа солилцож ажиллана.	Нас залуу, туршлага бага зэрэг ялгаатай байдлаар нь бусдыг үл тоомсорлох, үл хүндэтгэх хандлага гаргахгүй.
Багийн эрх ашгийг дээдэлж, хамт олны үүрэг, хувь нэмрийг үнэлж, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	Суралцагчид болон эцэг эх, олон нийтийн өмнө хамтран ажилладаг нэгнээ шүүмжлэх, буруушаах, нэр төрийг гутаахгүй.
Хамт олон дотроо ажил хэрэгч, бүтээлч үүр амьсгал бүрдүүлэхэд нөлөөлж, манлайлал үзүүлнэ.	Хамт олны дунд санал бодлоо илэрхийлэхдээ хувь хүний нэр төрд халдахгүй.
Хамт олонтойгоо харилцахдаа хүндэтгэлтэй, хүлээцтэй, шударга байна.	Хов живийг дэвэргэх, талцаж хуваагдах, асуудлыг газар авахуулж хурцатгахгүй.
Шинэ залуу багш нарыг байнга дэмжиж, туршлагаа хуваалцаж, менторшип хөтөлбөр хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцоно.	Суралцагчдын дэргэд тоглоом шоглоомоор нэгнээ хочлох, хэт дотночилж дуудах (ялангуяа эсрэг хүйсний багшийг), биед нь хамаагүй хүрэх зэрэг үйлдэл гаргахгүй.
Эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаа	
Эцэг эхийн нийгмийн байдал, боловсрол, амьдралын түвшинг үл харгалзан хүндэтгэлтэй хандаж, тэдний үзэл бодлыг сонсож, шийдвэр гаргахдаа тэдний оролцоог хангана.	Хуульд зааснаас бусад тохиолдолд суралцагчийн болон гэр бүлийн хувийн мэдээллийг задруулах, гуравдагч этгээдэд хэлэхгүй.
Суралцагчийн онцлог, авьяас, хөгжлийн хэрэгцээ, сурлагын амжилт, зан төлөвийн талаар эцэг эхэд үнэн зөв мэдээлэл өгч, эцэг эхийг хүүхдээ дэмжиж, чиглүүлэхэд зөвлөгөө өгнө.	Суралцагчийн сул тал, алдааг эцэг эхэд нь доромжилсон өнгө аясаар хэлэх, бусадтай харьцуулж муучлан ярихгүй.
Эцэг эхтэй хамтарсан уулзалт, зөвлөгөөн, сургалт, арга хэмжээнд идэвхтэй оролцуулж, сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Уулзалт, хурал, ярилцлагад бэлтгэлгүй орж, эцэг эхийг үл тоомсорлосон хайнга хандлага гаргахгүй.
Эцэг эхийн асуулт, санаа зовнилыг хүлээцтэй сонсож, эерэг зөвлөмжөөр чиглүүлнэ.	Хүүхдийн сурлагын асуудлыг зөвхөн эцэг эхэд даатгаж, хамтын хариуцлагаа үгүйсгэхгүй.

Ангийн групп чат ашиглах дүрэм боловсруулж, эцэг эх, асран хамгаалагчдын хурал дээр танилцуулан хамтдаа мөрдөнө. Тухайн дүрэмд групп чатыг зөвхөн сургалт, анги хамт олны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл түгээх, солилцоход ашиглах бөгөөд хувийн асуудлаа хуваалцах, гомдол гаргах, эцэг эхчүүдийн хооронд маргаан өрнүүлэх байдлаар ашиглахгүй гэдгийг тодорхой заасан байна.	- Мэдээлэл түгээх цагийн хуваарь баримталж, орой, шөнө, амралтын цагаар чатаар төвөг учруулахгүй. - Ангийн групп чатанд суралцагчдын хувийн мэдээлэл (оноо, үнэлгээ, хувийн асуудал гэх мэт)-ийг ил тод байршуулахгүй.
Хичээл сургалттай холбоотой мэдээллийг ойлгомжтой, товч тодорхой байдлаар хүргэх, эцэг эх, асран хамгаалагчдын асуултад соёлтой, хүндэтгэлтэй, товч тодорхой хариулна.	Мэдээллийг тодорхойгүй, олон дахин засварласан байдлаар ангийн группт оруулж, эцэг эх, асран хамгаалагчдын дунд үл ойлголцол үүсгэхгүй.
Олон нийттэй харилцах харилцаа	
Сургуулийн нэр хүндийг өндөрт өргөж, олон нийттэй харилцахдаа эерэг, ёс зүйтэй байр суурь баримтална.	Хэвлэл мэдээлэл болон сошиал орчинд сургууль, хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдын нэр хүндийг унагах сөрөг байр суурь илэрхийлэхгүй.
Сурагч, эцэг эх, иргэд болон хэвлэл мэдээлэлтэй харилцахдаа үнэн зөв, тодорхой мэдээлэл өгч, үл ойлголцол үүсгэхээс зайлсхийнэ.	Олон нийттэй харилцахдаа хувийн үзэл бодлоо сургуулийн байр суурь байдлаар илэрхийлэхгүй.
Сошиал орчинд сургуулийн нэрийн өмнөөс мэдээлэл түгээхдээ хариуцлагатай, албан ёсны эх сурвалжид тулгуурлана.	Сошиал сүлжээнд сурагч, эцэг эхийн хувийн мэдээлэл болон сургуулийн дотоод мэдээллийг нийтлэхгүй.
Нутгийн иргэд, төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллахдаа тэднийг хүндэтгэж, хамтын ажиллагаанд эерэгээр оролцоно.	Олон нийтийн өмнө ёс зүйд үл нийцэх зан харилцаа, үйлдэл гаргаж, байгууллагын нэр хүндийг сэвтээхгүй.



ТЕХНОЛОГИЙГ ХАРИУЦЛАГАТАЙ, ЁС ЗҮЙТЭЙ АШИГЛАХ ХЭМ ХЭМЖЭЭ



Үндсэн ойлголтууд:

- Боловсролын орчинд технологийг хариуцлагатай ашиглах
- Боловсролын орчинд технологийг ёс зүйтэй ашиглах
- Ёс зүйн зөрчил ба үр дагавар



Хичээлийн үйл явц:

	Үйл ажиллагаа	Цаг
1	Үйл ажиллагаа 5.1 Мэдээлэл хүргэх хэсэг	10 минут
2	Үйл ажиллагаа 5.2 Үндсэн хэсэг	15 минут
4	Үйл ажиллагаа 5.3 Дүгнэлт хэсэг	5 минут
	Нийт	30 минут



Арга зүй:

- Лекц (Үндсэн ойлголтуудыг тайлбарлах)
- Ярилцлага, хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер
- РРТ танилцуулга
- Богино видео (цахим орчин дахь ёс зүйн асуудлын жишээ)
- Тараах материал
- Хавсралт 1. Кейсүүд



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 5 минут

Сургагч багш “Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ” сэдэв рүү шилжиж байгааг оролцогчдод анхааруулж хэлнэ.

Үйл ажиллагаа 5.1. Кейс хэлэлцүүлэг – Багийн ажил (20 минут)

1. Сургагч багш өмнөх багийн гишүүдийг хольж, дахин 4 багт хуваана.
2. Баг бүрээс нэг оролцогч ирж, сугалаагаар Хавсралт 1 дэх кейсийг авна.
3. Багууд өгөгдсөн кейстэй танилцаад дараах даалгаврыг гүйцэтгэнэ:
 - Тухайн кейсэд ямар ёс зүйн асуудал гарсан бэ?
 - Багш, сурагчийн хувьд ямар хариуцлага үүсч болох вэ?
 - Дахин давтахгүйн тулд ямар арга хэмжээ авах вэ?
4. Баг бүр зөвлөмжөө дэлгэц цаасан дээр бичиж, 2–3 минутын танилцуулга хийнэ.

Үйл ажиллагаа 5.2 Үндсэн хэсэг – Танилцуулга (5 минут)

Сургагч багш РРТ ашиглан үндсэн ойлголтуудыг тайлбарлана.

Үйл ажиллагаа 5.3 : Дүгнэлт - 5 минут

Сургагч багш богино хэмжээний видео үзүүлнэ (цахим орчинд гарч болох ёс зүйн зөрчилтэй холбоотой, кейс дээрх агуулгатай ижил видеог РРТ ард оруулсан тул сургагч багш шууд хэрэглэх боломжтой).

Видео үзсэний дараа сургагч багш

- Багуудын дүгнэлтийг нэгтгэж, гол санааг тодруулна.
- “Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах нь зөвхөн хуулийн бус, харин хүний эрхийг хүндэтгэх, итгэлцлийг хамгаалах үндэс юм” гэсэн гол санаагаар сургалтыг хаана.

Кейс 1

Багш Э 12-р ангийн сурагчдад эцсийн шалгалтын оноог гаргасны дараа ангийн Facebook группт “Шалгалтын оноо – ангилал” нэртэй Excel файл нийтэлжээ.

Файлд сурагчдын нэр, код, оноо, өмнөх улирлын дундаж, ирц, багшийн дүгнэлт зэрэг бүх мэдээлэл орсон байв. Нэг сурагч маш бага оноо авсан нь ангийнхны дунд яриа болж, тухайн сурагч ичээд хичээлдээ ирэхгүй байгаа.

Кейс 2

Нэгэн ахлах ангийн англи хэлний багш Б өөрийн хувийн Facebook хуудсандаа амралтын өдрүүдээр найз нөхөдтэйгээ зугаалсан зургууд, заримдаа согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой бичлэг, шог сэтгэгдэл, улс төрийн хурц агуулгатай нийтлэл байнга нийтэлдэг байв. Эдгээр нийтлэлийг сурагчид болон эцэг эхчүүд чөлөөтэй үзэх боломжтой байсан бөгөөд нэг эцэг эх сургуулийн захиргаанд гомдол гаргасан.

Кейс 3

Багш А сургуулийн цахим платформ болох Google Classroom ашиглан хичээлээ удирддаг. Тэрээр нэг өдөр сургуулийн компьютер дээр өөрийн Google бүртгэлээр нэвтрээд гарахгүй орхисон байна. Дараа нь тухайн компьютерыг ашигласан сурагч А багшийн Classroom руу орж, шалгалтын материалыг урьдчилан үзэх, зарим дүнг өөрчлөх зэрэг үйлдэл хийжээ. Энэ үйл явдал илэрсний дараа багш, захиргаа болон эцэг эхчүүдийн хооронд үл ойлголцол үүсэж, мэдээллийн аюулгүй байдлын асуудал сөхөгдөв.

Кейс 4

“Манай нэг залуу багш инстаграм, тик ток маш идэвхтэй ашигладаг, нилээд олон дагагчтай. Цахим хуудас дээрээ ил задгай хувцасласан зургуудаа байнга тавьдаг. Өөрөө ч сайхан бүсгүй. Гэхдээ тэр зураг, бичлэгүүдийнх нь дор ангийнх нь хүүхдүүд “Манай багш хөөрхөн” гэх мэт коммент бичсэн байхыг нь би цөөнгүй удаа харж байсан. Нэг удаа нийтэлж байгаа зурагнууддаа анхааралтай хандаж байх тухай хэлэхэд “Би чөлөөт цагаараа өөрийнхөө хувийн орон зайд дуртай зүйлээ хийнэ.” гэж хэлсэн.

СЭДЭВ 3



ЁС ЗҮЙН АСУУДАЛ ГАРАХАД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛС



Хичээлийн зорилго:

Багш өөрийн ажил мэргэжлийн орчинд тулгардаг бэрхшээл, ёс зүйн алдаа, зөрчил гаргахад нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар эргэцүүлж, сөрөг нөлөөг таньж илрүүлэх үр чадварт суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Хувийн ба мэргэжлийн үнэт зүйлийн зөрчил
- Тогтсон хэвшмэл ойлголт
- Ажлын ачаалал ёс зүйн алдаа, зөрчил гаргахад нөлөөлдөг шалтгаан



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал	10 минут
2	Үйл ажиллагаа 2. Хэлэлцүүлэг	10 минут
3	Үйл ажиллагаа 3. Мэдээлэл өгөх	15 минут
4	Үйл ажиллагаа 4. Бүлгийн ажил	20 минут
5	Үйл ажиллагаа 5. Дүгнэлт	5 минут
Нийт		60 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн ажил (Бүлгээр ажиллаж, санал дэвшүүлэх)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер
- РРТ танилцуулга



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 26-29 дүгээр хуудас



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 5 минут

Сургагч багш нь урьдчилан бэлтгэсэн РРТ ашиглан Ёс зүйн зөрчлийн талаарх ойлголтыг оролцогчдод тайлбарлаж өгнө.

Үйл ажиллагаа 2: Хэлэлцүүлэг – 10 минут

Сургагч багш нь оролцогчдоос дараах асуултуудыг асууж, самбарт тэмдэглэнэ.

- Багш ёс зүйн хэм хэмжээгээ зөрчихөд нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
- Эдгээр шалтгаануудын хэдэн хувь нь хувь хүнээс, хэдэн хувь нь бүтэц тогтолцоо, бусад зүйлсээс хамааралтай байдаг гэж бодож байна вэ?

Оролцогчдоос гарч буй хариулт дунд хувь хүний үзэл бодол, итгэл үнэмшил, ёс зүйн талаарх ойлголт мэдлэг дутмаг, сургуулийн хэмжээнд ёс зүйн дүрмийн хэрэгжилт сул, хяналт муу, бие биедээ шаардлага тавих соёл төлөвшөөгүй, ажлын ачаалал их байх... гэх мэт хүчин зүйлс нөлөөлдөг тухай гарч байгаа эсэхийг анзаарч, чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 3: Мэдээлэл өгөх – 15 минут

Сургагч багш РРТ ашиглан ёс зүйн зөрчил гарахад нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар тайлбарлана.

Үйл ажиллагаа 4: Бүлгийн ажил – 20 минут

Оролцогчдыг 5-6 гишүүнтэй, 4 багт хувааж, дараах сэдвүүдийн дагуу түгээмэл тохиолддог жишээнүүдийг тэмдэглэж, эдгээр тохиолдлуудад хэрхэн хариу арга хэмжээ авч ажиллах талаар багаараа ярилцан тодорхойлж, бүх багууд бие биедээ танилцуулга хийх даалгавар өгнө.

- 1-р баг: Тогтсон хандлага, мэргэжлийн үнэт зүйлсийн зөрчлийн амьдралд түгээмэл тохиолддог жишээ
- 2-р баг: Ёс зүйн дүрэм журам тодорхой бус, хяналт сул байдлаас үүддэг асуудлууд
- 3-р баг: Ёс зүйн талаарх ойлголт мэдлэг сул байдлаас үүддэг асуудлууд
- 4-р баг: Ажлын ачаалал их байдлаас үүддэг асуудлууд

Дүгнэлт - 5 минут

“Бидний олонх нь ёс зүйн зөрчил гарч байгааг хөндлөнгөөс харж байсан, зарим тохиолдолд өөрсдөө ёс зүйн алдаа гаргаж байсан гэдгийг харлаа. Ийм нөхцөлд юу хийх, юуг анхаарах ёстой тухай, хэнээс тусламж дэмжлэг авч болох талаар дараагийн сэдвээр дэлгэрүүлэн ярилцах болно” гэж хэлээд оролцогчдоос лавлах зүйл байгаа эсэхийг асууж, дараагийн үйл ажиллагаа руу шилжиж байгааг хэлнэ.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Хэлэлцүүлэг хийх явцад оролцогчид ёс зүйн зөрчил гаргахад нөлөөлдөг шалтгааныг ажлын ачаалал, байгууллагын соёл гэх мэт гадны хүчин зүйлс рүү хэт хазайлгахгүй байхад анхаарна. Хэдийгээр ёс зүйн зөрчил гарахад нөлөөлдөг олон шалтгаан байдаг боловч багш нар хамгийн түрүүнд өөрөөсөө хамаарах харилцаа, хандлага, үйлдэлд анхааралтай хандаж, асуудлаас урьдчилан сэргийлэх нь нэн тэргүүний зүйл гэдгийг энэ сэдвийн хүрээнд оролцогчид ойлгож авах нь чухал юм. Мөн аливаа асуудлын талаарх тухайн хүний хувийн үзэл бодол мэргэжлийн ёс зүйтэй зөрчилдөж байвал яг энэ тохиолдол дээр өөртөө илүү хянамгай хандаж, мэргэжлийн ёс зүйгээ нэгт тавина гэдгийг оролцогчдоор өөрсдөөр нь дүгнэлт хийлгэхэд чиглүүлээрэй.



ЁС ЗҮЙН АСУУДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗҮЙ



Хичээлийн зорилго:

Урьдчилан сэргийлэх анхдагч, хоёрдогч, гуравдагч стратегийн ялгаа, онцлог болон хэрэгжүүлэх жишээний талаар ойлголтоо нэмэгдүүлнэ.



Үндсэн ойлголтууд:

- Урьдчилан сэргийлэх 3 түвшний стратеги
- Анхдагч урьдчилан сэргийлэлт
- Хоёрдогч урьдчилан сэргийлэлт
- Гуравдагч урьдчилан сэргийлэлт



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал	10 минут
2	Үйл ажиллагаа 2. Мэдээлэл өгөх	10 минут
3	Үйл ажиллагаа 3. Хэлэлцүүлэг	20 минут
5	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт	5 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн ажил (Бүлгээр ажиллаж, санал дэвшүүлэх)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- РРТ танилцуулга
- Дэлгэц цаас
- Маркер
- Самбарын цаас 3 ш
- Тараах материал
- Хавсралт 1. Урьдчилан сэргийлэх 3 түвшний стратеги



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 33-36 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 10 минут

Сургагч багш нь оролцогчдоос дараах асуултуудыг асууж, самбарт тэмдэглэнэ.

- “Танай сургууль багш, ажилтнуудаа ёс зүйн зөрчил гаргахаас хэрхэн урьдчилан сэргийлдэг вэ? Ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
- Гарсан асуудлыг цаг алдаж, хүндрүүлэлгүй амжилттай таслан зогсоож байсан туршлага бий юу?” гэж асуун, 3-4 хариулт авна.

Үйл ажиллагаа 2: Мэдээлэл өгөх – 10 минут

Сургагч багш нь урьдчилан бэлтгэсэн РРТ ашиглан Урьдчилан сэргийлэх 3 түвшний стратегийг танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Ярилцлага – 20 минут

Сургууль бүр урьдчилан сэргийлэх чиглэлээр янз бүрийн ажил зохион байгуулдаг юм байна. Эдгээр ажлууд нь анхдагч, хоёрдогч, гуравдагч шатны урьдчилан сэргийлэлтийн алинд нь илүү тохирч байна вэ? Танай сургууль дээр төдийлөн хэрэгждэггүй урьдчилан сэргийлэлтийн түвшин байгаа эсэхийг анзаарна уу. Яагаад хэрэгждэггүй вэ? Асуудал гарахгүй байна уу? Гардаг хэдий ч хэрэгжүүлж чадахгүй байна уу? гэдгийг эргэцүүлэн бодохыг хүснэ.

Сургагч багш нь оролцогчдод бодох боломж олгохын тулд цөөн хэдэн хором хүлээх зуураа 3 ширхэг самбарын цаас хананд нааж, тус бүр дээр нь Анхдагч, Хоёрдогч, Гуравдагч урьдчилан сэргийлэлт гэж бичнэ.

Дараа нь оролцогчдыг саналаа хэлэхийг урьж, гарсан саналуудыг аль тохирох хэсэгт нь тэмдэглэнэ. Хэрэв мэдээлэл бичигдээгүй хэсэг үлдвэл шалтгааныг нь асууж, ярилцана. Энэ хэсэг дараагийн сэдвийн хүрээнд ашиглагдах тул бүх оролцогчдод харагдахуйц газар тогтоосон хэвээр нь үлдээнэ.

Дүгнэлт – 5 минут

Сургагч багш нь “Урьдчилан сэргийлэх гурван түвшний стратеги нь зөвхөн ёс зүйн асуудлын хүрээнд бус, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг бүхий л салбарт өргөнөөр хэрэглэх боломжтой арга юм. Иймд байгууллага, хувь хүн аль аль нь энэхүү стратегийн онцлогийг ойлгож, хэрэгжүүлснээр эрсдэлт асуудал, нөхцөл байдлыг бууруулж чадна” хэмээн хичээлийг дүгнээд, дараагийн сэдвээр түвшин тус бүрийг нарийн задалж ярилцана гэдгийг оролцогчдод хэлнэ.

Урьдчилан сэргийлэх 3 түвшний стратеги

Анхдагч урьдчилан сэргийлэлт

Зорилго:	Зорилтот бүлэг:	Жишээ:
Эрсдлийг үүсэхээс нь өмнө бууруулах, сөрөг үзэгдлийг гарахаас нь өмнө арилгах	Нийт багш нар	Нийт багш нарт ёс зүйн тухай ойлголт өгөх, мэргэжлийн ёс зүйн дүрмийг таниулах сургалт зохион байгуулах



Хоёрдогч урьдчилан сэргийлэлт

Зорилго:	Зорилтот бүлэг:	Жишээ:
Асуудлыг эрт илрүүлэх, хүндрэхээс нь өмнө таслан зогсоох	Эрсдэлтэй зан авир гаргаж байсан багш нар	Мэргэжлийн хил хязгаараа баримталдаггүй, ёс зүйн дүрэм зөрчдөг багш нарт сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах



Гуравдагч урьдчилан сэргийлэлт

Зорилго:	Зорилтот бүлэг:	Жишээ:
Аль хэдийн үүссэн асуудлыг шийдвэрлэх, дахин үүсэхээс сэргийлэх	Ёс зүйн асуудлаар сахилгын болон хуулийн хариуцлага хүлээсэн багш	Дахин ёс зүйн алдаа гаргахаас сэргийлэх зөвлөгөө, зан үйлийн өөрчлөлтийн сургалтад хамруулах... гэх мэт



АНХДАГЧ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



Хичээлийн зорилго:

Анхдагч урьдчилан сэргийлэлтийн зорилго, хамрах хүрээ, сургуулийн түвшинд хэрэгжүүлж болох аргууд, тэр дундаа багш нарын мэдвэл зохих ёс зүйн асуудлууд, шийдвэр гаргах алхмуудын талаар ойлголтоо нэмэгдүүлнэ.



Үндсэн ойлголтууд:

- Анхдагч урьдчилан сэргийлэлт
- Ёс зүйн урхи, ёс зүйн хоёрдмол байдал (дилемма)
- Ёс зүйн шийдвэр гаргах 5 шатлалт алхам
- Багшийн ёс зүйн дүрэм



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Хэлэлцүүлэг	20 минут
3	Үйл ажиллагаа 3. Мэдээлэл өгөх	40 минут
5	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт хэсэг	5 минут
Нийт		70 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн ажил (Бүлгээр ажиллаж, санал дэвшүүлэх)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- РРТ танилцуулга
- Дэлгэц цаас
- Маркер
- Тараах материал
- Хавсралт 1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм – оролцогчдын тоогоор
- Хавсралт 2. Ёс зүйн урхи кейс – 2 хувь
- Хавсралт 3. Ёс зүйн хоёрдмол байдал (дилемма) – 2 хувь



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхэд хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 36-45 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал - 5 минут

- Анхдагч урьдчилан сэргийлэлтийн зорилго болон зорилтот бүлгийг талаар оролцогчдоос асууж, сэргээн сануулна.

Үйл ажиллагаа 2: Хэлэлцүүлэг – 20 минут

Сургагч багш нь сургалтын эхэнд танилцуулагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг дахин сануулж,

- Та бүхэн энэ дүрмээ хэр сайн мэдэх вэ?
- Хэр олон удаа уншдаг вэ?
- Дүрмийг сануулах, хэрэгжүүлэх талаар сургалтад хамрагдаж байсан уу?
- Дүрэмд заасан зүйлсээс нэрлэнэ үү? гэж асуугаад самбарт хариултуудыг нь тэмдэглэнэ.

Сургагч багш бүх оролцогчдод дээрх дүрмийг тараан өгч, анхааралтай уншиж, өөрийн хараахан анзаараагүй, эсвэл мэддэггүй заалтын доогуур зурж тэмдэглэхийг хүснэ.

Оролцогчдыг уншиж байх хооронд сургагч багш 4 ш самбарын цаас дээр

1. Суралцагчдын өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
2. Ажил мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
3. Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ
4. Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ гэж бичээд самбарт эгнүүлэн наана.

Оролцогчдыг дүрмээ уншиж дууссаны дараа цаасан дээрээ тэмдэглэсэн, төдийлөн анзаардаггүй, эсвэл сайн мэддэггүй байсан хэсгүүдээ хуваалцахыг хүсээд, хэлсэн зүйлсийг нь цаасан самбарт тэмдэглэнэ. Ингэхдээ дүрмийн мэдлэгийг шалгах шалгалт авч байгаа биш гэдгийг оролцогчдод сануулна. Энэ нь оролцогчид мэдэхгүй байгаа байдлаасаа ичих, санаа зовох асуудал гаргалгүй, сургалтаа чөлөөтэй үргэлжлүүлэхэд дэмжлэг болох юм.

Дараа нь энэхүү дүрмийг бүх багш сайн мэддэг, баримталдаг байх нь анхдагч урьдчилан сэргийлэлт хийх хамгийн эхний, хамгийн чухал алхам учир хүн бүр ёс зүйн дүрмээ ойр ойрхон уншиж, өөртөө дүгнэлт хийж явахыг уриалаад, дараагийн үйл ажиллагаа руу шилжиж байгааг хэлнэ.

Үйл ажиллагаа 3: Мэдээлэл өгөх – 40 минут

Сургагч багш “Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх явцад ёс зүйн төрөл бүрийн асуудал тулгардаг бөгөөд түүнийг таньж мэдэж чадахгүйгээс өөрөө анзааралгүй, эсвэл “ганц удаа гайгүй байлгүй дээ” гэж бодсоноос үүдэн ёс зүйн зөрчил гаргах, улмаар тэр нь хүндрэх тохиолдлууд байдаг. Үүнийг мэддэг байх нь багш нарыг аливаа асуудлаас сэргийлэх, эрт таслан зогсоход тусалдаг” гэж хэлээд оролцогчдыг 4 багт хуваагдахыг хүснэ.

Улмаар 2 багт нь ёс зүйн урхи, 2 багт нь ёс зүйн хоёрдмол байдал (дилемма)-ын кейс, нэмээд 4 багт бүгдэд нь “Шийдвэр гаргалтын 5 шатлалт алхам”-ыг танилцуулсан тараах материал өгөөд ажиллах хугацаа өгнө. Багууд ажиллаж дуусаад хариултаа 3 танилцуулна.

Сургагч багш урьдчилан бэлтгэсэн PPT ашиглан Ёс зүйн урхи, Ёс зүйн хоёрдмол байдал (дилемма)-ын талаар үндсэн ойлголтыг өгөх ба ингэхдээ багуудын ажилласан кейсүүдийн хариултыг танилцуулна.

Дүгнэлт – 5 минут

Сургагч багш нь “Анхдагч урьдчилан сэргийлэлт нь хэдий чинээ сайн хийгдэнэ, төдий чинээ ёс зүйн асуудал гарахаас сэргийлж чадна. Энэ нь зөвхөн дүрэм журам танилцуулж, “заавал биелүүл” гэж шахахаас гадна багш нарт тулгардаг асуудлуудаас хэрхэн зайлсхийж, өөрийгөө хамгаалах талаар арга зааж өгснөөр илүү бодитой сайн хэрэгжих боломж бүрдэх юм. Тиймээс ёс зүйн урхи, ёс зүйн хоёрдмол байдал, шийдвэр гаргах 5 алхамт аргачлалыг сайтар санаж, хэрэгжүүлж байгаарай” хэмээн хичээлийг дүгнэнэ.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Анхдагч урьдчилан сэргийлэлт нь нийт багш нарт зориулагдсан суурь мэдээллийг өгөх бөгөөд хамгийн түрүүнд мэргэжлийн ёс зүйн дүрмээ сайтар мэддэг байх нь чухал.

Оролцогчдод ЕБС-ийн багш нар нь “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг дагаж мөрдөхөөс гадна төрийн үйлчилгээний албан хаагчид учраас “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г мөн дагаж мөрдөх үүрэгтэй болохыг давхар сануулаарай.

Энэ сэдэв нь бага цагт их агуулга өгөх тул сургагч багш бэлтгэлээ сайтар хангаж, сургалтыг зохион байгуулах шаардлагатай. Ёс зүйн урхи, ёс зүйн хоёрдмол байдал (дилемма) гэсэн хоёр ойлголтын ялгааг сургалтын гарын авлагаас уншиж, сайтар ойлгосон байхыг анхаарна уу. Учир нь эдгээр ойлголтууд нь кейсүүд дээр ижил төстэй мэт харагддаг ч үр дагавар нь ялгаатай. Ёс зүйн урхи нь анхнаасаа тухайн асуудлын буруу тал нь тодорхой байдаг боловч, хор хохиролгүй мэт харагдснаар хүнийг буруу алхам хийлгэж занганд оруулдаг бол ёс зүйн хоёрдмол байдал (дилемма) нь сонголт хийх хоёр шийдвэрийн аль нь ч туйлын зөв, туйлын буруу биш бөгөөд алийг нь ч сонгосон нөгөө талынхаа эрх ашгийг хөнддөг тохиолдол юм.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл.

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны албан үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх мэргэжлийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, хүлээх хариуцлагыг тогтоож, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Багш, ажилтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн талаар эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

1.3. Энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэст үндсэн орон тоонд болон түр гэрээгээр ажиллаж буй багш, ээлжийн болон туслах багш, багшлах дадлага хийж буй оюутан, удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа ажилтан, албан хаагч (цаашид багш, ажилтан гэх) сахин мөрдөнө.

Хоёр. Багш, ажилтны эрхэмлэх үнэт зүйлс.

2.1 Багш, ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ дараах үнэт зүйлсийг эрхэмлэнэ.

- 2.1.1. Суралцагчийн эрх, аюулгүй байдал, нэр хүнд;
- 2.1.2. Төрийн албан хаагчийн болон багш мэргэжлийн нэр хүнд;
- 2.1.3. Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш, хүндэтгэлтэй, эерэг харилцаа;
- 2.1.4. Багшийг хүндлэн дээдлэх олон нийтийн итгэл үнэмшил.

Гурав. Багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ

3.1. Багш, ажилтны дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дор дурдсанаар ангилна.

- 3.1.1. Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;
- 3.1.2. Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;
- 3.1.3. Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;
- 3.1.4. Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ.

Дөрөв. Багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн шаардлага

4.1. Багш, ажилтан нь энэ журмын 3.1-д заасан мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний хүрээнд дараах ёс зүйн шаардлагыг мөрдөнө.

4.2. Энэ дүрмийн 3.1.1-д дурдсан “Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ” ний хүрээнд:

4.2.1.Боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ суралцагч бүрийн эрх, нэр төр, үндэс угсаа, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэнд, танин мэдэхүйн онцлог, ялгаатай байдал, нийгмийн байдал, суралцах чадвараар ялгаварлан гадуурхахгүй, соёлын олон талт байдалд хүндэтгэлтэй, тэгш хандах;

4.2.2.Суралцагчид бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт үзүүлэх, хүчээр албадахаас татгалзах;

4.2.3.Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад олж авсан суралцагчийн болон түүний гэр бүлийн нууцыг ажил эрхлэх хугацаанд болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсноос хойш бүхий л хугацаанд чандлан хадгалах, мэдээлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн 5 зөвшөөрсний дагуу мэдээлэх;

4.2.4.Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө суралцагчаас шан харамж, бэлэг, авлига авах, бусдад зуучлах, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив, тоног төхөөрөмж, эд материал өгөхийг шаардах, ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулахаас татгалзах;

4.2.5.Сургалтын орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, эрүүл мэнд хохирох, дарамт, ялгаварлан гадуурхалд өртөх, сөрөг нөлөөнд автахаас урьдчилан сэргийлэх;

4.2.6.Суралцагчид мэдлэг, чадвар, хандлага, харилцаа, хувцаслалт, биеэ авч явах байдал, арга барилаар зөв үлгэрлэх;

4.2.7.Суралцагчийн өмнө зүй бус үг хэллэг, үйлдэл гаргах, хууль, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ зөрчихөөс сэргийлэх;

4.2.8.Сургалтын агуулга, хөтөлбөрт зааснаас бусад тохиолдолд үлс төр, цэрэг дайн, шашин, нийгмийг хамарсан өвчин тахал болон бусад асуудлаар хүүхдийг айдаст автуулахуйц эх сурвалжгүй мэдээлэл хийх, хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх;

4.3. Энэ дүрмийн 3.1.2-д заасан “Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ”-ний хүрээнд:

4.3.1.Ажил, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, хууль тогтоомж, дүрэм журам, бусад эрх зүйн баримт бичгийг судалж мэдэх, хувийн үзэл бодлоос үл хамааран дагаж мөрдөх;

4.3.2.Өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэлийг шударга, бодитой үнэлэх;

4.3.3.Ажлын байр, олон нийтийн газар болон цахим орчинд бусадтай харилцахдаа ажил, мэргэжлийнхээ нэр хүндэд харшлах аливаа үйл ажиллагаа, үг, үйлдэл, эс үйлдэхүйгээс татгалзах;

4.3.4.Хичээл сургалтын явцад, сургалтын орчинд хууль бус үйл ажиллагаа, жагсаал цуглаан, шашны зан үйл зохион байгуулах, оролцох, бусдыг оролцохыг тулган шаардах, суралцагчийг татан оролцуулахаас татгалзах;

4.3.5.Ажил эрхлэх, албан тушаал дэвшихдээ боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвараа үнэн зөв мэдүүлэх, баримт бичгээр нотлох;

4.3.6.Албан байгууллагын нэр, албан тушаалын бүрэн эрхийг хувийн зорилгоор ашиглахаас татгалзах;

4.3.7.Ажлын алдаа дутагдлын талаарх шударга, үнэн бодит шүүмжлэлд хүндэтгэлтэй хандах, алдаа дутагдлаа засах, сайжруулах хандлага, чадвартай байх;

4.3.8.Багш, ажилтан нь өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээх чадвартай байх.

4.4.Энэ дүрмийн 3.1.3-д заасан “Хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, харилцагч байгууллага, олон нийтийн өмнөх хүлээх ёс зүйн хэм хэмжээ”-ний хүрээнд:

4.4.1.Боловсролын харилцаанд оролцогч багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэн, үйлчлүүлэгчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлдэг ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохгүй байх;

4.4.2.Хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, саналын зөрүүтэй тохиолдолд бусдад хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг эерэгээр шийдвэрлэхэд мэргэжлийн үр чадвар, манлайлал үзүүлэх;

4.4.3.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны явцад үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх, нэр төрийг хүндэтгэх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;

4.4.4.Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас аливаа урамшуулал, бэлэг, шан харамж шууд болон шууд бусаар авах болон бусдад зуучлахаас татгалзах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлээс сэргийлэх;

4.4.5.Зүй бүс үг, үйлдэл, зан байдлаараа албан харилцааны хэвийн байдал, хамт олны эв нэгдэл, уур амьсгалыг алдагдуулах, бусдыг хууль бус үйл ажиллагаанд уриалах, турхирахыг цээрлэх;

4.4.6.Ажлын байранд архидаг согтуурах, бусдыг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, ажлын байрны болон бэлгийн дарамт шахалт үзүүлэхээс цээрлэх;

4.4.7.Багш, ажилтан нь гүйцэтгэлийн үнэлгээ болон бусад шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээнд оролцохдоо шударга байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй бол татгалзах;

4.4.8.Өөрийн мэдлэг, чадвар, туршлага, ажил хэргийн мэдээ, мэдээллийг хамтран ажиллагчтай хуваалцахаас үл татгалзах;

4.4.9.Албан үүргээ гүйцэтгэхд нь бусдад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхгүй байх;

4.4.10.Удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг хэрэгжүүлэхээс үл татгалзах;

4.4.11.Албан тушаалын бүрэн эрх, давуу байдлаа ашиглан багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид хууль бус шаардлага, үүрэг даалгавар өгөхгүй, шийдвэр гаргахгүй байх, хууль бус үүрэг, шийдвэрийг үл биелүүлээгүйн төлөө хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, дарамт шахалт үзүүлэхгүй байх;

4.5.Энэ дүрмийн 3.1.4-д заасан “Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ”-ний хүрээнд:

4.5.1.Багш, ажилтан нь суралцагч, хамт олон, эцэг, эх асран хамгаалагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийгмийн сүлжээ, технологиор дамжуулан боловсролын аливаа харилцаанд оролцохдоо энэ дүрмийн 4.2, 4.3, 4.4-д заасан ёс зүйн хэм хэмжээг баримтлах;

4.5.2.Багш, ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсөн албаны цахим шуудангийн хаягийг ашиглах, албан хэрэгтээ хувийн цахим

хаягийг ашиглахаас татгалзах;

4.5.3.Нийгмийн сүлжээнд үзэл бодол, хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэхдээ ажил, мэргэжлийнхээ нэр хүндийг дээдлэн, багш, суралцагчдад буруу үлгэр дууриал үзүүлэхээс зайлсхийх, эх сурвалж нь тодорхой бус мэдээ, мэдээлэл түгээхээс урьдчилан сэргийлэх;

4.5.4.Технологийн дэвшлийн талаар зохих мэдлэгтэй, зүй зохистой хэрэглээтэй байх;

4.5.5.Цахим технологи ашиглан боловсруулсан багш, ажилтан, суралцагчийн мэдээлэл, бүртгэл, боловсролын баримт бичгийн нууцлалыг хангах, хамгаалах;

4.5.6.Технологи ашиглан хууль бус үйл ажиллагаанд оролцох, бусдын нууцыг задруулахаас урьдчилан сэргийлэх;

4.5.7.Цахим хичээл, контент бүтээх, ашиглахдаа оюуны өмчийн хууль тогтоомжийн зөрчил гаргахгүй байх;

4.5.8.Эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтан, суралцагчийн зөвшөөрөлгүйгээр тэдний зураг, бичлэгийг нийгмийн сүлжээнд нийтлэх болон ажил хэргийн зорилгоор авсан зураг, бичлэгийг хувийн ашиг сонирхол, бусдын нэр хүндэд халдах зорилгоор ашиглахыг цээрлэх;

4.5.9.Албан хэрэгцээний эд хогшил, тоног төхөөрөмж, цахим хэрэглэгдэхүүнийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

Тав. Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

5.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр батлагдсан хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ.

5.2.Байгууллагын ёс зүйн зөвлөл нь багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлаар шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган ажил олгогчид танилцуулна.

5.3.Ёс зүйн зөвлөл нь багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах үүрэг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хууль 7 тогтоомжид өөрөөр заагаагүй бол ёс зүйн хэм хэмжээг сахиулах, дүрэм, журмын биелэлтийг хангуулах зорилгоор зөвлөлөөс зөвлөмж, шаардлага гаргаж болно.

5.4.Зөвлөлийн дүгнэлтээр ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол багш, ажилтанд албан ёсоор мэдэгдэж, ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

5.5.Багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзвэл томилох эрх бүхий этгээд холбогдох хууль, журамд заасны дагуу ёс зүйн хариуцлагыг ногдуулах шийдвэрийг бичгээр гаргана.

5.6.Багш, ажилтны гаргасан зөрчил нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

5.7.Багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасны улмаас сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

5.8.Ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн зөвлөлийн дүгнэлтээр нотлогдсон багш, ажилтанд хариуцлага ногдуулаагүй, ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, саналыг хэрэгжүүлээгүй сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчид томилох эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.9. Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

5.10. Багш, ажилтанд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.

Зургаа. Бусад.

6.1. Ажил олгогч нь багш, ажилтны ёс зүйн байдалд хяналт тавих, холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

6.2. Ажил олгогч нь ёс зүйн хууль тогтоомжийг шинээр ажилд орж буй багш, ажилтанд заавал танилцуулж, ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, багш, ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулна.

6.3. Ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулах сургалт, үйл ажиллагааг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгаж, хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

6.4. Томилох эрх бүхий албан тушаалтан багш, ажилтанд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн багш, ажилтны хувийн хэрэгт хавсаргаж, боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэн, хамт олонд мэдээлнэ.

6.5. Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын ёс зүйн зөвлөл, аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Боловсролын ерөнхий газар удирдлага зохион байгуулалтаар хангаж, дээд шатны байгууллагад жил бүр тайлагнах үүрэг хүлээнэ.

6.6. Боловсролын харилцаанд оролцогч эцэг эх, асран хамгаалагч, олон нийт нь багшийн нэр төрийг хүндлэн, багш, ажилтныг хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, суралцагчийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр хууль ёсны шаардлагыг биелүүлэх, санаатай болон болгоомжгүйгээр хичээл сургалтыг үйл ажиллагааг тасалдуулахгүй байх хэм хэмжээг мөрдөнө.

6.7. Сургалтын байгууллага нь эцэг эх, асран хамгаалагчидтай байгуулах гэрээнд багш, бусад суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид хүндэтгэлтэй, тэгш хандах, эерэг зөв харилцах чиглэлээр ёс зүйн хэм хэмжээг тусгаж болно.

6.8. Энэхүү дүрмээр зохицуулаагүй харилцааг Засгийн газрын 2019 оны “Дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон бусад холбогдох хууль, дүрэм, журмаар зохицуулна.

Хавсралт 2.

“Ёс зүйн урхи” кейс

“...Шалгалтын комисст орсон шинэхэн багш өглөө шалгалт явагдах ангид ирээд ахлах багшийн хавтас дотор нэг сурагчийн шалгалтын хариулт бөглөгдсөн байхыг санамсаргүй харчихав. Энэ тухай ахлах багшаасаа асуутал “Энэ хүүхдийн гэр бүл асуудалтай, сэтгэл санаа нь хүнд байгаа. Жаахан тус болох гэсэн юм” гэж хэллээ.

Шинэ багш үүнийг шударга бус гэж бодсон ч ахлах багштайгаа зөрчилдөж, таагүй уур амьсгал үүсгэхээс зайлсхийн дуугүй өнгөрлөө.

Хэд хоногийн дараа шалгалтын дүн зарлагдахад тус сурагч хамгийн өндөр оноог авч, бусад сурагч, эцэг эхчүүдээс шалгалтын талаар гомдол иржээ. Захирал, сургалтын менежер хоёр шинэ багшаас “Та шалгалтын материал яагаад задарсныг мэдэж байна уу?” гэж асуусан...”

Ёс зүйн урхи хэрхэн үүссэн бэ?

Хавсралт 3.

“Ёс зүйн хоёрдмол байдал” кейс

“...8 дугаар ангийн сурагч нь гэр бүлийнхээ асуудлаасаа болж сүүлийн үед сэтгэл санаа нь хямарч, байнга гутардаг болсон тухайгаа багшдаа хэлжээ. Тэрээр энэ тухай хэнд ч мэдэгдэхгүй байхыг хүссэн бөгөөд багшдаа сэтгэлээ хуваалцах гэж л ярьсан байна. Гэвч энэ асуудал цаашид үргэлжилсээр байвал хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй гэж багш үзсэн. Тиймээс хүүхдийг сургуулийн сэтгэл зүйчтэй холбохоос гадна нийгмийн ажилтантай хамт эцэг эхтэй нь уулзаж ярилцах хэрэгтэй. Гэвч багш энэ асуудлыг бусадтай хуваалцвал сурагч “нууц задруулсан” гээд түүнд итгэхээ больж мэднэ. Харин нууцыг хадгалж үлдвэл тэр аюулд орж болзошгүй...”

Ёс зүйн хоёрдмол байдал (дилемма) хэрхэн үүссэн бэ?



ХОЁРДОГЧ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



Хичээлийн зорилго:

Хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн зорилго, хамрах хүрээ, сургуулийн түвшинд зохион байгуулж болох аргууд, ёс зүйн эрсдэл гаргаж болзошгүй багш нарын өөрийгөө үнэлэх, өөртэйгөө ажиллах арга замуудын талаар суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Хоёрдогч урьдчилан сэргийлэлт
- Өөрийн үнэлгээ
- Өөрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Үндсэн хэсэг	10 минут
3	Үйл ажиллагаа 3. Өөрийн үнэлгээ	25 минут
5	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт	5 минут
Нийт		45 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн ажил (Бүлгээр ажиллаж, санал дэвшүүлэх)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- РРТ танилцуулга
- Дэлгэц цаас
- Маркер
- Тараах материал
- Хавсралт 1. Мэргэжлийн ёс зүйн өөрийн үнэлгээ оролцогчдын тоогоор
- Хавсралт 2. Стрессийн түвшин тодорхойлох үнэлгээ оролцогчдын тоогоор
- Хавсралт 3. Өөрийн хөгжлийн төлөвлөгөөний загвар оролцогчдын тоогоор



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхдийн эрх, хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 45-54 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал хэсэг - 5 минут -

Хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн зорилго болон зорилтот бүлгийг давтан сануулна.

Үйл ажиллагаа 2: Хэлэлцүүлэг – 10 минут

Сургагч багш нь оролцогчдод багшийн сөрөг харилцаа хандлагыг харуулсан кино, шторкны хэсгээс харуулаад, дараах асуултуудыг асууна.

- Ийм харилцаа хандлага гаргадаг, эсвэл өөр хэлбэрээр ёс зүйн алдаа гаргадаг багш нар байдаг уу?
- Ямар асуудал түгээмэл гаргадаг вэ?
- Энэ талаар хэн нэгэн гомдол гаргаж байсан уу? Үгүй бол яагаад?
- Үүнийг таслан зогсоох талаар сургууль, удирдлага, ёс зүйн зөвлөлөөс ямар нэг ажил хийгдэж байсан уу? гэж асуун хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Сургагч багш нь хэлэлцүүлгийн хүрээнд ямар нэг байдлаар албан ёсны хариуцлага хүлээгээгүй бөгөөд тухайн үйлдлээ давтсаар байдаг багш нарын талаар ярихад чиглүүлнэ.

- Энэ асуудал хүндэрвэл ямар эрсдэл дагуулж болох вэ?
- Одоо хүүхдүүд, хамт олон, хамтран ажиллагч болон олон нийтэд хэрхэн нөлөөлж байгаа бол? гэдэг асуултыг үргэлжлүүлэн асууна.

Үйл ажиллагаа 3: Өөрийн үнэлгээ – 25 минут

Сургагч багш “Бид сая бусдын тухай ярилцсан. Одоо өөрийгөө үнэлэх цаг ирлээ” гэж зарлаад “Мэргэжлийн ёс зүйн өөрийн үнэлгээ”-г оролцогч бүрт тараан өгнө.

Дараа нь “Энэ үнэлгээний хариулт нууц байх бөгөөд таны хариултыг хэн ч харахгүй. Тиймээс та бүхэн асуумжаа бөглөхдөө сайтар бодож, өөртөө үнэнчээр хариултаа өгөөрэй” гэж тайлбарлаад, оролцогчдод асуумжуудыг уншиж, хариулах цаг өгнө.

Бүгд дууссаны дараа “Стрессийн түвшин тодорхойлох үнэлгээ”-г тарааж өгөөд, ажиллах 5 минутын хугацаа өгнө. “Багшийн мэргэжлийн стресс, ажлын ачаалал нь тэдний ёс суртахууны шийдвэр, үнэт зүйлсийн дагуу ажиллах чадварт шууд нөлөөлдөг”. (Christopher Day) болох нь судалгаагаар батлагдсан гэдгийг оролцогчдод тайлбарлаж өгөөд, стрессийн түвшин дунд бөгөөд их байвал онцгой анхаарах хэрэгтэйг сануулна.

Эцэст нь өөрийн хөгжлийн төлөвлөгөөний загварыг бүх оролцогчдод тараан өгч, “Сая ажилласан 2 төрлийн өөрийн үнэлгээ дээр өөрийнхөө анхаарч сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлсон байх. Одоо та бүхэн энэ загварыг ашиглаад сайжруулахыг хүссэн хэсгүүдийг зорилго болгон бичиж, өөрийнхөө хувийн хөгжлийн

төлөвлөгөөг зохиогоорой. Энэ бол гэрийн даалгавар шүү” гэж тайлбарлана.

Энэ хичээлийн талаар сэтгэгдлээ сайн дураараа хуваалцахыг хүссэн оролцогч байгаа эсэхийг асууж, 2 оролцогчийн сэтгэгдлийг сонсоно. Хэрэв сайн дурын оролцогч байхгүй бол хэн нэгнийг сэтгэгдэл хэлэхийг албадахгүй.

Дүгнэлт – 5 минут

Сургагч багш нь “Хоёрдогч урьдчилан сэргийлэлт нь анхдагч урьдчилан сэргийлэлттэй харьцуулахад хамрах хүрээ нь бага хэдий ч яг эрсдэлтэй хүн рүүгээ чиглэдэг тул сайн хэрэгжүүлж чадвал тухайн хүнийг болон бусдыг эрсдлээс урьдчилан сэргийлж чадна. Гэхдээ эрсдэлтэй хүн рүү чиглэж ажиллана гээд бусдын нэр хүндийг гутаах байдалд хүргэхээс ямагт болгоомжлох хэрэгтэй” гэж сануулаад энэ хэсгийг дүгнэж хаана.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Багшийн ёс зүйн асуудал нь эмзэг сэдэв учраас сургалтын бүхий л хугацаанд сургагч багш нь аливаа төрлийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчид санал сэтгэгдэл хэлэх, туршлагаа хуваалцах үед хэн нэгний түүхийг ярихдаа нэрийг нь дурдах, амархан танигдаж болохуйц содон шинж тэмдгийг нь хэлэхгүй байхыг сэдэв бүрийн эхэнд сануулна.

Ялангуяа хоёрдогч болон гуравдагч урьдчилан сэргийлэлт сэдвийн хүрээнд ёс зүйн зөрчил гаргах эрсдэл бүхий зан үйлтэй, зөрчил гаргасны улмаас хариуцлага хүлээсэн багш нарт чиглэсэн үйл ажиллагааг ярилцах үед сургагч багш илүү хянамгай, анхаарал болгоомжтой байх хэрэгтэй. Энэ сэдэв нь оролцогчид өөрсдөдөө тохиолдсон зүйл, хувийн туршлагаа онцлон ярилцах үйл ажиллагаа биш. Оролцогчдын сэтгэл хөдлөлийг аль болох доод түвшинд байлгах, тэдний нууцыг хадгалах, аль нэг оролцогчийг эвгүй байдалд оруулахгүй байх үүднээс багаар ажиллах, асуудлыг ерөнхийд нь авч үзэхийг сануулж, тэднийг чиглүүлнэ.

Сургагч багш нь энэ сэдвийн дасгал ажлыг явуулахдаа оролцогчдыг “Манай сургуульд ёс зүйн зөрчил гаргаж болзошгүй ямар багш нар байдаг билээ? Тэд ямар үйлдлүүд гаргадаг билээ?” гэсэн байдлаар буруутай этгээдүүдийг хайж олж, хэлэлцэх нөхцөл рүү хазайн орохоос сэргийлнэ. Харин оролцогчид өөр дээрээ төвлөрч, “Миний өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ? Би ёс зүйн алдаа гаргадаг бил үү? Надад ямар эрсдэлтэй зан үйлүүд байдаг вэ?” гэдгийг эргэн харж, өөртөө дүгнэлт хийж, дутагдалтай талуудаа сайжруулахад нь чиглүүлнэ гэдгийг анхаарна уу.

Зорилго:

Энэ үнэлгээ нь стрессийн түвшинг тодорхойлж, өөрийгөө үнэлж, эргэцүүлэхэд чиглэгдсэн.

Хэрэглэх заавар:

Доорх 21 асуулт бүрийг анхааралтай уншаад, өөрийн бодит хандлагад нийцсэн хариултыг (✓) тэмдэглэж, эргэлзээтэй асуултад (!) тэмдэг, хэрэгжүүлдэггүй асуултад (х) тэмдгээр тэмдэглэнэ үү.

Асуултууд

Зааварчилгаа: Та дараах асуулт, хариултуудыг уншаад өөрт тохирохыг дугуйлна уу. Хариулж дуусаад оноогоо нэмээрэй.

1. Та өөрийн хооллох хэв маягийнхаа талаар ямар бодолтой байдаг вэ? Та өлсөөгүй үедээ юмуу стресс хүндрэлээ даван туулахын тулд хооллодог уу?
 - А. Үгүй, би эрүүл хооллолттой. Зөвхөн өлссөн үедээ л хоол иддэг.
 - В. Би хааяа амттан идэх дуртай.
 - С. Тиймээ, миний хооллолт эрүүл бус гэдгээ би хүлээн зөвшөөрч байна.
2. Та дасгал хөдөлгөөн хийгээгүй байхад их хөлрөөд байна уу?
 - А. Үгүй
 - В. Заримдаа, ялангуяа стресст орсон үедээ хөлөрдөг.
 - С. Тиймээ, нэлээн элбэг тохиолддог.
3. Та хэзээ нэгэн цагт нойрны асуудалтай тулгарч байсан уу?
 - А. Ховорхон, ер нь л үгүй.
 - В. Хааяа би унтаж байгаад сэрээд дахиж унтдаг. Үе үе нойрондоо мууддаг.
 - С. Тиймээ би үнэхээр нойрны асуудалтай, унтаж чадахгүй байх явдал элбэг тохиолддог.
4. Таны ходоод өвдөх эсвэл ходоодны шарх үүссэн гэх мэт ямар нэгэн хоол боловсруулах замын асуудал тулгарч байсан уу?
 - А. Үгүй.
 - В. Хааяа ходоод өвдөх нь бий.
 - С. Тиймээ, би хоол боловсруулах замын асуудалтай байнга тулгардаг.
5. Та хийж буй ажлаасаа халшрах, ямар нэгэн зүйлээс айж түгших юмуу сэтгэл гутралын улмаас шаналж байна уу?
 - А. Үгүй.
 - В. Би сайн мэдэхгүй байна.
 - С. Тийм.
6. Та өөртөө анхаарал тавьж, цаг гаргадаг уу?
 - А. Тиймээ, би өөрийнхөө бие болон сэтгэл санаанд анхаарал халамж сайн тавьдаг.
 - В. Би хүсч байгаа боловч өөртөө цаг гаргаж чадахгүй байна.
 - С. Үгүй, би өөртөө бага анхаарал тавьдаг.
7. Та бусадтай харилцах харилцаандаа цаг зав гаргадаг уу? Танд тусалж дэмждэг гэр бүлийнхэн, найз нөхөд бий юу?
 - А. Тийм. Миний найзууд болон гэр бүлийнхэн намайг стресстэй байх үед маш их тусалдаг.
 - В. Бага зэрэг. Ямар нэг зүйл миний санааг үнэхээр зовоосон үед л ойр дотны

хүмүүстээ ярьдаг.

С. Үгүй, би цөөхөн дотны найзтай учраас уулзалдах нь цөөн эсвэл би ойр дотны хүмүүстээ зориулж цаг гаргадаггүй байж болох юм.

8. Та дасгал хөдөлгөөн тогтмол хийдэг үү?

А. Тийм. Би идэвхтэй амьдралын хэв маягтай. Долоо хоногт хамгийн багадаа гурван удаа дасгал хөдөлгөөн хийдэг.

В. Янз бүр. Би заримдаа өдөр бүр ямар нэг дасгал хийдэг бол заримдаа долоо хоногт огт дасгал хийхгүй байх нь бий.

С. Үгүй, би хөдөлгөөн багатай амьдралын хэв маягтай, дасгал хөдөлгөөн хийхээр биеийн тамирын заал руу явдаггүй.

9. Та стрессээ тайлах гэж тамхи татах юмуу архи уудаг уу?

А. Үгүй

В. Би эдгээр зүйлүүдийн нэгийг нь хийдэг, гэвч энэ нь тийм ч сүртэй юм биш.

С. Тийм ээ, би эдгээрийг хэрэглэхгүй байж чаддаггүй.

10. Таны толгой байнга өвддөг үү?

А. Үгүй. Бараг өвддөггүй.

В. Янз бүр. Сард нэг юмуу хэд хэдэн удаа толгой өвддөг.

С. Тийм ээ, миний толгой байнга өвддөг.

11. Та жингээ барих гэж хичээж байна уу? Та хэт их таргалалттай юу?

А. Үгүй, миний жин байх ёстой жингээс 4 кг орчмоор л илүү.

В. Би ихэнх хүмүүсийн адил хоолны дэглэм барихыг хичээдэг, гэхдээ үргэлж биш.

С. Тиймээ энэ бол асуудал. Би жингээ барьж чадахгүй байна. Миний хамгийн асуудалтай хэсэг бол хэвлийн таргалалт юм.

12. Сүүлийн үед та амархан уурлаж бухимдаад байна уу?

А. Үгүй, намайг хямраасан асуудал л гарахгүй бол миний зан ааш тогтвортой байдаг.

В. Бага зэрэг. Би хүсч байгаа шигээ тэвчээртэй байж чаддаггүй. Гэхдээ энэ нь тийм ч чухал асуудал биш.

С. Тийм. Миний сэтгэлд хүрэхгүй зүйл их байна.

13. Сүүлийн нэг жилийн хугацаанд өвчний улмаас ажлаа хийж чадаагүй явдал хэр олон тохиолдсон бэ?

А. Магадгүй нэг удаа

В. Хоёр, гурван удаа

С. Дөрөв буюу түүнээс дээш

14. Та ихэнх орой маш их ядарснаа мэдэрдэг үү?

А. Ховорхон. Би ер нь оройдоо ч эрч хүчтэй байдаг.

В. Бага зэрэг. Би орой гэртээ ирээд жаахан амарч байгаад ажлаа хийдэг.

С. Тийм. Би ихэвчлэн үд дундаас эхлээд ядарч эхэлдэг.

15. Стресс таны эрүүл мэндийн байдалд нөлөөлж байна уу?

А. Үгүй. Би хэвийн, тайван байна.

В. Магадгүй. Гэхдээ би сайн мэдэхгүй байна.

С. Тийм. Стресс миний эрүүл мэндийн байдалд нөлөөлж байгааг би мэдэрдэг.

Үр дүнг боловсруулах:

А хариулт – 1 оноо, В хариулт – 2 оноо, С хариулт – 3 оноо тус тус өгөөрэй.

- 15- 24 оноо – бага түвшин
- 25-34 оноо – дунд түвшин
- 35-аас дээш оноо – дээд түвшин

Бага түвшин

Таны стрессийн түвшин бага байна. Баяр хүргэе. Та өөрийн стрессээ зөв аргаар зохицуулж байгаа учраас таны эрүүл мэндийн байдал сайн байна.

Дунд түвшин

Танд стрессээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудал байна. Энэ нь таны эрүүл мэндэд одоохондоо ноцтой үр дагавар авчрахгүй байж болох хэдий ч стрессийн түвшин нэмэгдэж хүндрэхээс нь өмнө эрүүл амьдралын хэв маягийг сонгохыг зөвлөж байна. Заримдаа стрессийн түвшин нэмэгдэхэд түгшүүр болон цочрол гэмтэлийн дараах шинж тэмдэгүүдтэй ижил шинж тэмдгүүд илэрч болно.

Дээд түвшин

Таны стрессийн түвшин эрүүл мэндийн ноцтой үр дагавар учруулахуйц өндөр эрсдэлтэй түвшинд хэдийнэ тулж ирээд байна. Иймээс та эрүүл мэндээ хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж зөв амьдралын хэв маягийг сонгох хэрэгтэй болжээ. Та стресс эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг, стрессээ хэрхэн зохицуулах тухай мэдээллийг уншаарай. Хэрвээ танд тусламж хэрэгтэй байгаа бол харъяаллын сэтгэцийн эрүүл мэндийн төвүүдээс тусламж авч болно.

Зорилго:

Та мэргэжлийн ёс зүйгээ хэр баримталж ажиллаж байгаагаа өөрөө үнэлж, эргэцүүлэхэд зориулагдсан.

Хэрэглэх заавар:

Доорх 21 асуулт бүрийг анхааралтай уншаад, өөрийн бодит хандлагад нийцсэн хариултыг (✓) тэмдэглэж, эргэлзээтэй асуултад (!) тэмдэг, хэрэгжүүлдэггүй асуултад (х) тэмдгээр тэмдэглэнэ үү.

№	Асуултууд	✓	!	х
1	Өнгөрсөн 7 хоногт би бүх хүүхдэд ижил тэгш хандаж чадсан уу?			
2	Хэн нэг хүүхдийг илүү их анхаарах, эсвэл хайхрахгүй байх зэргээр ялгаварлах хандлага гаргаагүй биз?			
3	Хүүхдийн нууц, хувийн мэдээллийг ажлын шаардлагаас гадуур ямар нэг байдлаар задруулаагүй биз?			
4	Хүүхдүүдэд урам өгөх үг хэлсэн үү?			
5	Суралцагчдыг ичээх, айлгах үг хэллэг хэрэглэж, тэдэнд бие махбодын шийтгэл оногдуулаагүй биз?			
6	Хүүхдийн санаа бодлыг сонсох боломж өгсөн үү?			
7	Хүүхдийн аюулгүй байдлыг анхаарсан уу? Хүүхэд хамгааллын асуудлыг зүгээр орхиогүй биз?			
8	Би заах хичээлийнхээ бэлтгэлийг сайн хангасан уу?			
9	Өнгөрсөн 7 хоногийн хугацаанд би өөрөө шинэ зүйл сурах гэж оролдсон уу?			
10	Өөрийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд ямар нэг алхам хийсэн үү?			
11	Суралцагчдыг хувийн шинжтэй ажилдаа ашигласан уу?			
12	Суралцагчдын амжилтыг шударгаар үнэлсэн үү?			
13	Суралцагчдыг өөрийнхөөрөө байлгах гэж шахаж шаардаагүй биз?			
14	Хамт олонтойгоо найрсаг харилцсан уу? Тэдэнд дэмжлэг үзүүлсэн үү?			
15	Эцэг эх, асран хамгаалагч нартай харилцахдаа итгэл төрүүлэхүйц, мэргэжлийн байж чадсан уу?			
16	Сургууль дээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, бусад хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон уу?			
17	Тэмцээн уралдаан, арга хэмжээний тухай цахимд нийтлэхдээ хүүхдийн зураг, мэдээллийг зөвшөөрөл авалгүй тавиагүй биз?			
18	Цахим орчинд бусадтай харилцахдаа, үзэл бодлоо илэрхийлэхдээ зохисгүй үг хэллэг ашигласан уу? Бусдын нэр хүндэд халдсан уу?			
19	Сэтгэл санаагаа тогтвортой, эерэг байлгаж чадсан уу?			
20	Би өөрөө хичээлдээ хоцорч ирсэн үү?			
21	Хүүхдийн сайн сайхны төлөө ямар нэг санаачилга гаргасан уу?			

Үнэлгээний зөвлөмж:

(!) болон (х) тэмдгээр хариулсан асуулт бүрийг анхааралтай ажиглаж, яагаад ийм үйлдэл гаргах болсон шалтгааныг бодоорой. Гэхдээ өөрийгөө зөвтгөх байр суурь баримтлалгүй, “Яагаад ийм үйлдэл гаргасан бэ? Илүү сайнаар хэрхэн хийж болох вэ?” гэдэг асуултыг өөрөөсөө асууж, эргэцүүлэн бодно. Шаардлагатай тохиолдолд хэн нэгнээс уучлалт гуйхаа мартаж болохгүй юм.

Хавсралт 3.

Өөрийн хөгжлийн төлөвлөгөөний загвар

Хувийн хөгжлийн төлөвлөгөө гэдэг нь хувь хүн өөрийн мэдлэг, хандлага, үр чадвар, үнэт зүйлс болон амьдралын зорилгоо системтэйгээр тодорхойлж, шат дараатай ахиц дэвшил гаргах замын зураглал юм. Энэ төлөвлөгөө нь зөвхөн мэргэжлийн үр чадвар дээшлүүлэхээс гадна хувь хүний ёс зүй, харилцааны соёл, цагийн менежмент, сэтгэл зүйн тэнцвэрийг хадгалах зэргээр өөрийгөө үр дүнтэй хөгжүүлэхэд тусалдаг

Өөрийгөө хөгжүүлэх үйл явц нь тухайн хүн өөрийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, зорилгоо төлөвлөн хэрэгжүүлсний дараа үр дүнгээ үнэлж, дараагийн төлөвлөгөөг гаргах байдлаар тасралтгүй үргэлжилдэг.



Нэр:	Эхлэх огноо:	Дуусах огноо:
Миний зорилго: Суралцагчидтай харилцах харилцааны үр чадвараа нэмэгдүүлэх, нэг жилийн дотор суралцагчдаас багш нарын зан харилцааны талаар авдаг үнэлгээний үзүүлэлтийг хамгийн багадаа 30 хувиар нэмэгдүүлэх	Миний одоогийн бодит байдал: Миний багшлах үр чадвар сайн хэдий ч янз бүрийн зан ааштай суралцагчидтай харилцахдаа өөрийнхөө хүсээнээр байлгах гэж уурладаг, тэдэнтэй тайван харилцах арга барил дутдаг.	Бусдын үнэлгээ: Нийгмийн ажилтан намайг “бусдыг сайн сонсдоггүй, хүлээц муутай, өөрийгөө их хамгаалдаг” гэж хэлсэн. Зарим эцэг эхчүүд “түргэн ааштай, хүүхдүүдтэй ширүүн дориун харилцдаг, тайван бус зан харилцаатай” гэсэн.
Миний хийх зүйлс: • Сургуулийн сэтгэл зүйчтэй 7 хоногт 1 удаа зөвлөгөө авч, даалгавар биелүүлэх • Долоо хоногт 2 цагийг ёс зүйн мэдлэг болон харилцааны үр чадварын ном, гарын авлага уншихад зориулах • Сард дор хаяж 1 удаа ёс зүйн кейс хэлэлцүүлэг зохион байгуулах эсвэл оролцох • Харилцааны үр чадварын сургалтад хамрагдах • Эцэг эх, суралцагчидтай харилцахдаа өөртөө хяналт тавьж, илүү эерэг, ил тод харилцах аргыг хэрэгжүүлэх	Надад байгаа боломжууд: • Сургуулийн сэтгэл зүйчээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах • Ёс зүйн сургалт, семинарт оролцох • Багшийн ёс зүйн кейс хэлэлцүүлэгт оролцох • Багшийн ёс зүйн талаар ном, гарын авлага унших • Зөвлөх, ахлах зэрэгтэй олон жилийн туршлагатай, ёс зүйн асуудал гаргаж байгаагүй багшаас менторын зөвлөгөө авах	Явцын үнэлгээ: • 2 сарын дараа: Нэг ёс зүйн сургалтад оролцсон, нэг ёс зүйн ном уншсан, нэг кейс хэлэлцүүлэг зохион байгуулсан байх • 4 сарын дараа: Сэтгэл зүйчтэй 12 удаагийн үулзалт хийж, хувийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтээ 50% хүргэсэн байх 6 сарын дараа: Суралцагч болон эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах арга барил дээр бодит өөрчлөлт гарсан байх
Эцсийн үнэлгээ: Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр багшийн ёс зүйн талаарх мэдлэг, чадвар, дадал зуршил сайжирч, сургуулийн хэмжээнд эерэг үүр амьсгал бий болгоход хувь нэмэр оруулсан байхыг зорино.	Дахин үнэлгээ хийж, дараагийн шинэ төлөвлөгөө гаргах:	



ГУРАВДАГЧ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ



Хичээлийн зорилго:

Гуравдагч урьдчилан сэргийлэлтийн зорилго, хамрах хүрээ, ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага хүлээсэн багшийг алдаагаа дахин давтахаас урьдчилан сэргийлэх талаар өөртэйгөө ажиллах, сургуулийн ёс зүйн зөвлөл дэмжлэг үзүүлэх арга замуудын талаар суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Гуравдагч урьдчилан сэргийлэлт
- Мэргэжлийн удирдлагаар хангах
- Хяналтад чиглэсэн хандлага ба дэмжлэгт чиглэсэн хандлага
- Өөрчлөлтийн үе шатны загвар



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа		Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Ярилцлага	15 минут
3	Үйл ажиллагаа 3. Мэдээлэл өгөх	20 минут
4	Үйл ажиллагаа 4. Багийн ажил	30 минут
5	Үйл ажиллагаа 5. Дүгнэлт хэсэг	5 минут
Нийт		75 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн ажил (Бүлгээр ажиллаж, санал дэвшүүлэх)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- РРТ танилцуулга
- Дэлгэц цаас
- Маркер



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхдийн эрх, хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 54-58 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал хэсэг - 5 минут

Гуравдагч урьдчилан сэргийлэлтийн зорилго болон зорилтот бүлгийг давтан сануулна.

Үйл ажиллагаа 2: Ярилцлага – 15 минут

Сургагч багш нь оролцогчдоос “Танай сургууль дээр аль нэг багш ёс зүйн ноцтой зөрчил гаргаж байсан бол тэр үед гуравдагч урьдчилан сэргийлэлтээр ямар алхам хийж байсан бэ?” гэж асуун ярилцлага эхлүүлнэ. “Тэдгээр алхамууд үр дүнгээ өгсөн үү? хэмээн үргэлжлүүлэн асууна.

Хэлэлцүүлгийг хөтлөхдөө хэн нэгнийг онцолж, тохиолдсон асуудлыг нь задалж ярихгүй, асуудалд ерөнхий байдлаар хандаж, ярилцана гэдгийг оролцогчдод сануулна.

Үйл ажиллагаа 3: Мэдээлэл өгөх – 20 минут

Сургагч багш РРТ ашиглан мэргэжлийн удирдлагаар хангах, хяналтад чиглэсэн хандлага ба дэмжлэгт чиглэсэн хандлага, өөрчлөлтийн үе шатны загварын үндсэн ойлголтуудыг танилцуулна.

Улмаар “Та бүхэн өөрчлөлтийн үе шатны загварын дагуу хүний зан үйлийг өөрчлөх үүрэг хүлээж байгаа биш юм. Гэхдээ хүний зан харилцаа, аливаа дадал зуршил өөрчлөгдөхдөө эдгээр замуудыг туулдаг гэдгийг та бүхэн мэдэж байх нь зүйтэй. Жишээлбэл, танай ангийн тааруу сурлагатай суралцагч сайн их сургуульд орохыг хүсэж, хичээлдээ сайжрахыг оролдож эхлэх үед ч энэ 5 үе шатыг дамждаг. Тиймээс та үүнийг мэддэг байснаар тухайн хүүхдэд хэрэгтэй үед нь зөв дэмжлэгийг үзүүлж чадах юм” хэмээн тайлбарлана.

Үйл ажиллагаа 4: Багийн ажил – 30 минут

Сургагч багш нь нэг сургуулиас ирсэн оролцогчид нэг баг болж суухыг урина. Дараа нь урьдчилан сэргийлэх 3 түвшний стратегийг бүтнээр нь харуулж, дахин сануулна.

Сургалтын гарын авлагыг бүх оролцогчдод тараан өгч, 37, 46, 49-р хуудсуудыг харахыг хүснэ. Тэдгээр хуудсууд дээр анхдагч, хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэлтийн хүрээнд сургуулийн Ёс зүйн зөвлөлийн хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийг санал болгосон байна.

Сургагч багш “Та бүхэн эдгээр санал, зөвлөмжүүдийг уншаад, өөрийн сургууль дээр урьдчилан сэргийлэх 3 түвшний стратегийн хүрээнд хэрэгжүүлж болох үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргана уу” гэж урина.

“Та бүхэн сургуулийнхаа ёс зүйн зөвлөлийн гишүүн биш байж болно. Гэхдээ та тухайн сургуулийн багш учраас ямар үйл ажиллагаа зохион байгуулбал сургуулийн орчин ёс зүйтэй, тааламжтай уур амьсгалыг улам сайжруулж болох вэ гэдгийг бодож, бүтээлчээр хандаарай. Мөн энд хийсэн төлөвлөгөөгөө сургуулийнхаа удирдлага, ёс зүйн зөвлөлд

танилцуулбал тэдний ажилд чухал дэмжлэг үзүүлэхээс гадна таны энэ сургалтад цаг хугацаагаа зарцуулж оролцсоны нэг чухал үр дүн болох юм” гэж хийж буй дасгалынх нь ач холбогдлыг тайлбарлан хэлнэ.

Дүгнэлт – 5 минут

Сургагч багш нь “Бид урьдчилан сэргийлэх гурван түвшний стратегийг үзэж дууслаа. Эдгээр стратегиуд харилцан уялдаа холбоотой тул аливаа асуудлыг зөвхөн нэг түвшинд үлдээх бус бүх түвшинд зэрэг авч үзэж чадвал хамгийн үр дүнтэй.

Бид энэ гурван стратегийг өдөр тутмын ажил амьдралдаа хэрэгжүүлснээр асуудлаас сэргийлээд зогсохгүй, хүүхэд, багш, хамт олон, байгууллага бүрийн хөгжил, сайн сайхныг дэмждэг соёлыг бий болгож чадна.

Урьдчилан сэргийлэлт гэдэг бол нэг удаагийн арга хэмжээ биш, харин тогтвортой дадал, хамтын хариуцлага юм. Иймээс та бүхэн цаашдаа өөрийн ажил, орчиндоо эдгээр стратегийг ашиглаж, зөвхөн асуудлаас зайлсхийх биш, боломжийг бүтээдэг, эрсдэлийг урьдчилан арилгадаг дадалтай болохыг хүсье.” хэмээн хичээлийг дүгнэнэ.

Эцэст нь сургагч багш багшийн ёс зүйн хэсгийг ингээд өндөрлөж байгааг хэлээд дараагийн сэдэв “Хүүхдийн эрх, хамгаалалд багшийн үүрэг” болохыг танилцуулснаар хичээлийг дуусгана.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Урьдчилан сэргийлэх 3 түвшний стратегийн хамгийн эмзэг сэдэв буюу хэн нэгэн алдаа гаргаж хариуцлага хүлээсэн багшийн нэр төрийг шууд хөндөж болзошгүй учраас энэ сэдвийг сургагч багш анхааралтай удирдаж явуулна. Өмнөх сэдэв дээр дурдсанчлан аливаа төрлийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчид хэн нэгний кейсийг онцолж ярихгүй, санал сэтгэгдэл хэлэх, туршлагаа хуваалцах үедээ бусдын нэрийг нь дурдахгүй, амархан танигдаж болохуйц содон шинж тэмдгийг нь хэлэхгүй байхыг сайтар сануулна.

Оролцогчдын зарим нь ёс зүйн зөрчил гаргасны улмаас хариуцлага хүлээж байсан багшийг мэддэг байх магадлалтай. Түүнээс гадна хариуцлага хүлээж байсан оролцогч ч анги дотор байж болзошгүй. Тиймээс асуудлыг ярилцах үед аль нэг оролцогч дуугаа хураах, оролцоо нь хумигдах, эвгүй байгаа нь мэдэгдэх зэрэг хариу үйлдэл гаргаж байгаа эсэхийг хянамгай ажиглана. Тийм оролцогч байвал сургалтын завсарлагаар бусад оролцогчдоос тусдаа газар түүнээс зүгээр эсэхийг лавлаж, амралт хэрэгтэй байна уу гэж асуугаарай.

Сэдвийн төгсгөлд сургууль бүр гурван түвшний стратегийг хэрэгжүүлэх өөрийн төлөвлөгөөний загварыг гаргах нь хамгийн чухал хэсэг юм. Сургагч багш нь хоёрдогч болон гуравдагч түвшний урьдчилан сэргийлэлтийн хүрээнд хийх ажлуудыг нь сайтар ажиглаж, хувь хүний нэр төр, ажлын байрны орон зай, ажил үүрэгт хэт халдсан байдлаар төлөвлөлт хийхээс зайлсхийхэд анхаарна. Жишээлбэл, ёс зүйн зөрчил гаргаж болзошгүй багш нарын талаар суралцагчид болон хамт олных нь дунд нэр цохсон судалгаа авах гэх мэт.

Нэмж судлах материалууд

- Стандартчилал, Хэмжил зүйн газар (2009). Монгол улсын стандарт: Дээд боловсрол: Мэргэжлийн чиглэл: Ерөнхий боловсролын сургуулийн багш. MNS 5323-95: 2009
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/545 дугаар тушаалын 2 дугаар хавсралт. (2022).
Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532345602431&showType=1>
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/545 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт. (2022).
Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532345574681&showType=1>
- УИХ, (2023). Төрийн албан хаагчийн тухай хууль
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759635984401>
- Засгийн газрын 109 дүгээр тогтоолын хавсралт. (2024). Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141630877621&showType=1>
- Greenwald, A. G., & Banaji, M. R. (1995). Implicit social cognition: Attitudes, self-esteem, and stereotypes. Psychological Review.
<https://psycnet.apa.org/record/1995-17407-001>
- Campbell, E. (2003). The Ethical Teacher. Open University Press.
https://books.google.mn/books/about/The_Ethical_Teacher.html?id=jiDT4Kd-Pas-C&redir_esc=y
- Daniel Kahneman (2011). Thinking, Fast and Slow.
<https://dn790002.ca.archive.org/0/items/DanielKahnemanThinkingFastAndSlow/Daniel%20Kahneman-Thinking%2C%20Fast%20and%20Slow%20%20.pdf>
- UNESCO (2019). Teacher's Guide on Preventing Discrimination in the Classroom
<https://www.unesco.org/en/inclusion-education>

ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДАЛД БАГШИЙН ҮҮРЭГ

	Агуулга	Судлах цаг
	Нийт судлах цаг	5
2.1	Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн дагаж мөрдөх хэм хэмжээ	1
2.2	Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх арга	2
2.3	Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл явц	2

Бүлэг сэдвийн зорилго

Багш нарын хүүхдийн эрх, хамгааллын талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх, хариу арга хэмжээ авах арга зүйд суралцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх.

Хүрэх үр дүн

- ЕБС-ийн багш нар хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох эрх зүйн хэм хэмжээний талаар үндсэн ойлголт мэдлэгтэй болж, боловсролын орчинд хуулийн хүрээнд ажиллах чадварт суралцана.
- Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгээ бататгаж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, илрүүлэх арга зүйд суралцана гэж болгох
- Сургуулийн орчинд мэдэгдсэн, сэжиглэгдсэн хүүхэд хамгааллын асуудлын талаарх мэдээллийг хүлээн авах, шилжүүлэх, хариу арга хэмжээ авах үйл явцын талаар ойлголттой болж, багшийн зүгээс анхаарч ажиллах арга зүйд суралцана.



ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДАЛД БАГШИЙН ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ



Хичээлийн зорилго:

Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох эрх зүйн хэм хэмжээний талаар үндсэн ойлголт мэдлэгтэй болж, боловсролын орчинд хуулийн хүрээнд ажиллах чадварт суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох үндэсний эрх зүйн хэм хэмжээ
- Хүүхдийн эрх, хамгаалалд ерөнхий боловсролын сургуулийн багшийн үүрэг



Хичээлийн үйл явц:

	Үйл ажиллагаа	Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал хэсэг	10 минут
2	Үйл ажиллагаа 2. Үндсэн хэсэг	15 минут
3	Үйл ажиллагаа 3. Дүгнэлт хэсэг	20 минут
	Нийт	45 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Ярилцлага хэлэлцүүлэг (Асуулт хариулт, харилцан ярилцах)



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер, скоч
- Тараах материал:
Хавсралт 1. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн үүрэг
Хавсралт 2. Багшийн үүрэг, холбогдох хуулиуд
Хавсралт 3. Багшийн дагаж мөрдөх эрх зүйн шаардлага, эрсдэл



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхдийн эрх, хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 53 – 57 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал хэсэг - 10 минут

Сургагч багш оролцогчдод дараах асуултад хариулж, ажиллахыг хүснэ. Үүнд:

- Нэгдүгээр асуулт: Сургуулийн орчинд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багш ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Энэ асуултын хүрээнд ажиллахдаа “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн үүрэг” тараах материалаас (Тараах материал 1) холбогдох заалтуудыг олж, хүснэгтийн (Тараах материал 2) эхний хэсэгт тэмдэглэхийг хэлнэ.
- Хоёрдугаар асуулт: Сургуулийн орчинд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багш дээрх үүргээ гүйцэтгэхдээ ямар ямар хуулиудыг үндэслэж ажиллах вэ? хариулахдаа хүснэгтийн (Тараах материал 2) арын хэсэгт тэмдэглэнэ гэдгийг сануулна.
- Сургагч багш оролцогчдын гүйцэтгэсэн ажил, дараа дараагийн үйл ажиллагаанд ашиглагдана гэдгийг хэлээд дэлгэц рүү анхаарлыг нь хандуулна.

Үйл ажиллагаа 2: Үндсэн хэсэг - 15 минут

Сургагч багш тусгайлан бэлтгэсэн “Хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багшийн дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ” слайдыг танилцуулна.

- Тухайн хичээлийн агуулгыг танилцуулах явцад оролцогчдыг өмнөх хийсэн ажлаа нягталж, тэмдэглэж явахыг сануулна.

Үйл ажиллагаа 3: Дүгнэлт хэсэг - 20 минут

Сургагч багш дараах асуултаар хэлэлцүүлэг хийж, дүгнэнэ.

- “Сургуулийн орчинд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багш үүргээ гүйцэтгэхдээ ямар ямар хуулиудын хүрээнд ажиллах шаардлагатай байна вэ?” асуултын хүрээнд оролцогчид хоёр хоёроороо ажиллаж, өмнө хийсэн ажлаа бие биедээ танилцуулна. Танилцуулсаны дараа нэг оролцогчийнхоо хийсэн хүснэгтийг ашиглаж саналаа нэгтгэнэ. Гүйцэтгэх хугацаа 2 минут байхаар тооцож ажиллахыг сануулна.
- “Сургуулийн орчинд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд багш яагаад эрх зүйн хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай вэ? асуултын хүрээнд ажиллаж, саналаа нэгтгэнэ. Гүйцэтгэх хугацаа 3 минут байхаар тооцож ажиллахыг сургагч багш сануулна.
- Оролцогчдыг ширээгээрээ нэг баг болж ажиллахыг хүснэ. Хоёр хоёроороо хийсэн ажлаа баг дотроо танилцуулж, багийн нэгдсэн саналыг гаргахдаа тарааж өгсөн загварын дагуу ажиллана (Тараах материал 3).

Танилцуулах явцад давхцаагүй саналуудыг хэлэхийг сургагч багш сануулаад гүйцэтгэх хугацаа 5 минут байхаар тооцож ажиллана.

- Сургагч багш 1-2 багийн ажлыг сонсоно (5 минут).
- Сургагч багш дараах мэдээллийг ашиглан хичээлээ дүгнээрэй (5 минут).
 - Ерөнхий боловсролын сургуулийн багш нь хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн хэм хэмжээг чанд мөрдөх нь зөвхөн хуульд заасан үүрэг төдийгүй хүүхдийн аюулгүй орчинд суралцах, хөгжих эрхийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой.
 - Багш нь эрх зүйн шаардлагыг хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын сургууль нь хүүхдэд ээлтэй, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэхд голлох үүрэг гүйцэтгэхээс гадна багш мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, мэргэжлийн хариуцлагыг сахин ажиллахад тулгуур нөхцөл болно.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Бэлтгэл:

- Сургагч багш хичээлд хэрэглэх тараах материал 1, 2-ыг оролцогчдын тоогоор хэвлэж тараана. Тараах материал 3-ыг багийн тоогоор хувилсан байна. Өмнөх өдрийн хичээлээр ажилласан багийн тоог харгалзана гэдгийг санаарай.
- Оролцогчдыг хоёр хоёроор, нэг багаар ажиллуулахдаа тэгш оролцоог хангаж ажиллах тухай сануулж, зарим багийн ажилд оролцоог хангах үүднээс ээлжлүүлж санал солилцоход дэмжлэг үзүүлээрэй.
- Оролцогчид багаар ажиллах явцад үзэл бодол зөрчилдөх, бие биенийхээ саналыг үгүйсгэж болзошгүй нөхцөл байдал үүсвэл сургагч багш өөрөө тухайн багийн ажилд оролцож ажиллаарай.

Үйл явц:

- Сургагч багш ерөнхий боловсролын сургуулийн багшийн дагаж мөрдөх хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн хэм хэмжээг ярихдаа өмнөх хичээлүүд болох багшийн ёс зүйтэй холбож тайлбарлана.
- Багш хуульд заасан үүргээ гүйцэтгэхээс гадна хүүхдийн эрхийг хангах, хүүхдийг хамгаалахад мэргэжлийн хил хязгаараа мөрдлөг болгох, сургуулийн гадаад, дотоод орчин хүүхдэд ээлтэй, аюулгүй байхад анхаарч ажиллана гэдгийг онцолж тэмдэглээрэй.
- Багш эрх зүйн хэмжээг дагаж мөрдөж ажиллаж чадахгүй бол хүүхдэд олон эрсдэлүүд үүсэх тул хууль эрхзүйн хүрээнд ажиллах чадвартай байх ёстой гэдгийг онцолж тайлбарлаарай.

13.2. БАГШИЙН ҮҮРЭГ (БЕХ, 2023)

- 13.2.1. Суралцагчид тогтоосон хугацаанд сургалтын хөтөлбөр, агуулгыг чанартай, бүрэн эзэмшүүлэх;
- 13.2.2. Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;
- 13.2.3. Суралцагчийн чадамжийг бодитой үнэлэх, тэдний авьяас, хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг судлан суралцахуйг дэмжих;
- 13.2.4. Суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих;
- 13.2.5. Суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;
- 13.2.6. Хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих;
- 13.2.7. Багшийн мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх;
- 13.2.8. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 13.2.9. Сургалтад цахим технологи, хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад цахим системийг ашиглах;
- 13.2.10. Ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;
- 13.2.11. Суралцагчийн эрхийг зөрчих болон сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, багш, удирдах ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;
- 13.2.12. Байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, бусад багш, ажилтан, суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;
- 13.2.13. Улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- 13.2.14. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;
- 13.2.15. Суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;
- 13.2.16. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;
- 13.2.17. Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;
- 13.2.18. Хуульд заасан бусад

Багшийн үүрэг, холбогдох хуулиуд

НЭГ. БАГШИЙН ҮҮРЭГ

ХОЁР. ХУУЛИУД

Багшийн дагаж мөрдөх эрх зүйн
шаардлага, эрсдэл

Эрх зүйн хэм хэмжээг дагаж
мөрдөхийн ач холбогдол

Эрх зүйн хэм хэмжээг дагаж
мөрдөхгүй бол үүсэх эрсдэл



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАНЬЖ ИЛРҮҮЛЭХ АРГА



Хичээлийн зорилго:

Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгээ бататгаж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх арга зүйд суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Хүүхдийн эрх, хүүхдийн эрхийн зөрчил
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний хэлбэр, илрэх шинж тэмдэг
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж, илрүүлэх арга



Хичээлийн үйл явц:

	Үйл ажиллагаа	Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал хэсэг	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Үндсэн хэсэг	30 минут
3	Үйл ажиллагаа 3. Багийн ажил	40 минут
4	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт хэсэг	15 минут
	Нийт	90 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн хэлэлцүүлэг
- Кейс шинжилгээ
- Багийн ажил



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер, скоч
- Тараах материал:
 - Хавсралт 1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейсүүд
 - Хавсралт 2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, үнэлэх хуудас



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхдийн эрх, хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 58-74 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал хэсэг - 5 минут

Сургагч багш оролцогчдоос дараах асуултыг асууна:

- Хүүхдийн эрхийн зөрчил гэж юуг хэлэх вэ?
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж юуг хэлэх вэ?

Сургагч багш 3-4 оролцогчийн саналыг сонсож, самбарт бичнэ. Оролцогчдын саналыг самбарт тэмдэглэх явцдаа хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл Монгол улсад түгээмэл асуудал болсон байгаа учраас багш бид нар энэхүү асуудлын талаар ойлголт мэдлэгтэй байж, асуудлыг шийдвэрлэхэд оролцох үүрэгтэй талаар хэлж үндсэн агуулга руу анхаарлыг чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 2: Үндсэн хэсэг - 30 минут

Сургагч багш тусгайлан бэлтгэсэн “Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, таньж илрүүлэх” слайдыг танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Багийн ажил - 40 минут

Сургагч багш нэг баг ойролцоогоор 5 гишүүнээс хэтрэхгүй байхаар төлөвлөж, оролцогчдыг 5-6 багт хуваарилна. Баг тус бүрээс нэг нэг оролцогч гарч ирж, сургагч багшийн өмнөх ширээн дээрээс нэг кейс сугална. Багууд сугалсан тухайн кейстэй танилцаж дараах даалгаврыг гүйцэтгэнэ:

- Тухайн кейст хүүхдийн ямар эрхүүд зөрчигдөж байна вэ?
- Тухайн кейс хүүхдийн эсрэг хүчирхийллийн ямар хэлбэр вэ? ямар шинж тэмдгүүд илэрч байна вэ?
- Тухайн кейсийн хүрээнд үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт бичнэ. (Даалгаврыг гүйцэтгэхдээ Хавсралт 2-ыг ашиглана)

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт хэсэг - 15 минут

Сургагч багш оролцогчдод тараасан цаасан дээр дараах асуултад хариулж бичээд самбарт наалгуулж, ярилцана.

- Өнөөдрийн хичээлээс сурч мэдсэн хамгийн чухал гурван санаа юу байсан бэ?
- Сурч мэдсэн мэдлэгээ та өөрийн сургалтын орчинд хэрхэн ашиглах вэ?
- Хүүхэд хамгааллын талаар өөрийгөө хөгжүүлэх шаардлагатай гэж бодож байна уу? Яагаад

Оролцогчдын хариултыг үндэслэн сургагч багш дараах дүгнэлтийг хийнэ.

- Багшийн хувьд хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэд хамгааллын талаар зөвхөн мэдлэгтэй байхаас гадна хүүхдийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, хүчирхийлэлд өртөж болзошгүй болон өртөх эрсдлийг илрүүлж, мэдээлэх үүрэгтэй гэдгийг бататгаж хэлнэ.
- Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх нь хүүхдийн амь нас, хөгжил, аюулгүй байдлыг хамгаалахад хамгийн чухал зүйл учраас багш хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних чадвартай байх шаардлагатайг онцлон тэмдэглэнэ.

Сургагч багшид зориулсан тэмдэглэл

Бэлтгэл:

- Сургагч багш Хавсралт 1-д байгаа сургалтын кейсийг нэг багт 3-4 байхаар тооцож, хэвлэж бэлтгэсэн байна.
- Сургагч багш Хавсралт 2-д байгаа ажиглалт, үнэлгээний хуудсыг оролцогчдын тоогоор хэвлэж бэлтгэсэн байна.

Үйл явц:

- Сургагч багш хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл өгөхөөр бол сургалтын гарын авлага, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд тодруулга хийнэ гэдгийг санаарай.
- Сургагч багш хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй кейс дээр ажиллах, дасгал даалгавар гүйцэтгэх явцад оролцогчдын зүгээс ойлгомжгүй, тодруулах зүйлд нээлттэй хандаж, тайлбарлалт сайн хийгээрэй.
- Сургагч багш тухайн хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх нь хүүхдийн амь нас, хөгжил, аюулгүй байдлыг хамгаалахад хамгийн чухал зүйл учраас багш хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних чадвартай байх нь хамгийн чухал гэдгийг тодотгон тайлбарлаарай.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейсүүд

6-р ангийн сурагч Б гурван өдөр дараалан хоцорч ирэв. Хичээл дээрээ нуруугаа түшиж сууж, гар, шуугаагаа ханцуйгаараа халхалж, байнга татаж хаадаг. Биеийн тамирын хичээлээр хувцсаа солиогүй, хувцсаа мартсан гээд хичээлд оролцоогүй. Ангийн хүүхдүүд түүний биеийг хөхөрсөн байсан гэдгийг багшид хэлсэн. Багш Б-гаас энэ тухай асуухад “унаад хөхөрсөн” гэж хариулсан. Гэвч гар, нуруунд нь 3-4 см хөхөрсөн сорви харагдав. Гэхдээ багштай ярилцах явцдаа Б аавдаа загнуулсан тухай хэлсэн.

7-р ангийн сурагч Г өмнө нь идэвхтэй оролцдог байсан ч сүүлийн үед гараа өргөхөө больсон. Шалгалтад үргэлж өндөр оноо авдаг байсан бол одоо маш бага оноо авдаг болсон. Ээж нь ангийн эцэг эхийн хурал дээр “миний хүүхэд чадваргүй, муу сурдаг” гэж олон нийтийн өмнө хэлэв. Энэ тухай ангийнхан нь мэдсэн бөгөөд түүнтэй найзлахаа больсон. Г өөрөө ганцаардах, найз нөхөдгүй болсон төдийгүй хичээлдээ идэвхгүй оролцох нь эрс нэмэгдэв.

9-р ангийн сурагч Д сүүлийн хоёр долоо хоног хичээлээс олон удаа чөлөө авчээ. Тэрээр ангийнхаа эрэгтэй хүүхдүүдтэй харилцахаас зайлсхийж, ганцаараа суудаг болсон. Багш юу болсон талаар асуухад охин гэнэт үйлж эхлэв. Тэр ахынх нь найз өөрийг нь орой бүр биед нь хүрдэг тухай ярих. Охин сургуулийн автобусанд явахдаа жолоочоос маш их айдаг нь анзаарагдсан. Тэр үргэлж зузаан хувцас өмсөх болжээ.

3-р ангийн сурагч Ө өдөр бүр өлсгөлөн ирдэг. Өнгөрсөн долоо хоногт хичээл дээр хоёр удаа ухаан алдсан. Хүүхэд байнга бохир хувцастай, хичээлийн дэвтэргүй ирдэг. Багш охиноос гэр бүлийнх талаар асуухад “аав архи уудаг, ээж хотод ажилтай” гэжээ. Тэр гэртээ ихэнхдээ ганцаараа байдаг тухай хэлсэн. Жин багатай, өсөлт нь үеийнхнээсээ хоцорсон байна.

Б 6-р ангид сурдаг, дуу цөөтэй, ангийнхаа бусад хүүхдээс намхан биетэй хүү. Сүүлийн саруудад ангийн гурван хөвгүүн түүнийг “бүдүүн, намхан” гэх мэт хочлон, завсарлагаар цүнхийг нь булааж тоглодог болсон. Бат энэ талаар ангийн багшдаа хэлээгүй, харин гэртээ ирээд дуугаа хурааж, хичээлээ хийх дургүй болжээ. Сүүлийн үед хичээлдээ анхаарал төвлөрөхгүй, хичээлээс хоцорч ирэх болсон бөгөөд гараа маажих, хүмсаа мэрэх зуршилтай болжээ. Багш нь Баттай ярилцахад “Надад найз байхгүй, надтай тоглох хүн байхгүй” хэмээн үйлсэн байна.

Л 13 настай, эцэг эхийнхээ хамт хөдөө амьдардаг. Гэр бүлийн санхүүгийн байдал муутул Л хичээлээ тараад мал хариулж, зах дээр урт цагаараа ажилладаг. Тэрээр өдөрт 10-12 цаг хөдөлмөрлөж, гэрийн даалгавраа хийж амждаггүй болсон. Сүүлийн үед хичээлээс хоцрох, зарим өдрүүдэд огт ирэхгүй байх нь нэмэгджээ. Ангийн багш нь Л-ыг ядарсан, нүдний доор хөхрөлттэй, анхаарал төвлөрөл муутай байгааг ажигласан. Л багшийн асуултад “Гэр бүлдээ мөнгө олохгүй бол бид хоолгүй хононо” гэж хариулсан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних,
үнэлэх хуудас

НЭГ. АЖИГЛАЛТЫН ХУУДАС

Хүүхдийн овог, нэр			
Хугацаа	☐ 7- 14 хоног ☐ 1 сар ☐ 2 сар ба түүнээс дээш		
Санамж:	Хүүхдийн зан байдал, биеийн болон сэтгэл зүйн өөрчлөлтийг системтэйгээр тэмдэглэх		
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр	Бие махбодод илрэх шинж	Зан үйлд илрэх шинж	Багшийн тэмдэглэл
☐			
☐			
☐			
☐			
Тэмдэглэл хөтөлсөн багшийн нэр, огноо			

НЭГ. ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Зорилго	Хүүхэд хамгааллын талаарх мэдээллийг хүлээн авах, шилжүүлэх, арга хэмжээ авах үйл явцын талаар ойлголттой болж, багшийн зүгээс анхаарч ажиллах арга зүйд суралцана.		
Шинж тэмдэг	Тийм	Үгүй	Тайлбар
Хүүхдийн биед тайлбарлахад төвөгтэй гэмтэл илэрсэн	☐	☐	
Хүүхэд сэтгэл санааны дарамтад байгаа шинжтэй	☐	☐	
Хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн шинжтэй	☐	☐	
Хүүхэд эцэг эхээсээ айдаг, зайлсхийдэг	☐	☐	
Хүүхэд байнга өлсгөлөн, бохир хувцастай ирдэг	☐	☐	
Хүүхэд цахим орчинд доромжлол, дарамтад өртсөн тухай ярьсан	☐	☐	
Гэр бүлийн орчин эрсдэлтэй (архидалт, ядуурал, үл хайхрал гэх мэт)			
Дүгнэлт			
Ажиглалт, үнэлгээ хийсэн багш: /			



ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДЛЫГ МЭДЭЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЙЛ ЯВЦ



Хичээлийн зорилго:

Сургуулийн орчинд мэдэгдсэн, сэжиглэгдсэн хүүхэд хамгааллын асуудлын талаарх мэдээллийг хүлээн авах, шилжүүлэх, хариу арга хэмжээ авах үйл явцыг талаар ойлголттой болж, багшийн зүгээс анхаарч ажиллах арга зүйд суралцана.



Үндсэн ойлголтууд:

- Сургуулийн хүүхэд хамгааллын үйл явц: мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх, мэдээлэлд хариу арга хэмжээ авах
- Сургуулийн хүүхэд хамгааллын үйл явцад оролцогч талууд



Хичээлийн үйл явц:

	Үйл ажиллагаа	Цаг
1	Үйл ажиллагаа 1. Удиртгал хэсэг	5 минут
2	Үйл ажиллагаа 2. Үндсэн хэсэг	30 минут
3	Үйл ажиллагаа 3. Багийн ажил	45 минут
4	Үйл ажиллагаа 4. Дүгнэлт хэсэг	10 минут
	Нийт	90 минут



Арга зүй:

- Бичил лекц (Сэдвийн дагуу мэдээлэл өгөх, тайлбарлан таниулах)
- Бүлгийн хэлэлцүүлэг
- Багийн ажил



Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас
- Маркер, скоч
- Тараах материал:
 - Хавсралт 1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейс
 - Хавсралт 2. ЕБС -ийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны тойм зураглал



Сургагч багшийн заавал уншиж судлах материал:

У.Пагма, Х.Өлзийтунгалаг, Ч.Должинсүрэн (2025) “Хүүхдийн эрх, хамгаалал ба Багшийн ёс зүй” сургалтын гарын авлага 75-78 дугаар хуудас.



Хичээлийн үйл явц:

Үйл ажиллагаа 1: Удиртгал хэсэг - 5 минут

Сургагч багш оролцогчдоос дараах асуултыг асууна:

- Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл илэрсэн, мэдэгдсэн тохиолдолд багш нар хаашаа, хэрхэн мэдээлдэг вэ?
- Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийн дагуу хэн ямар хариу арга хэмжээ авдаг вэ?

Сургагч багш 3-4 оролцогчийн саналыг сонсож, самбарт бичнэ. Оролцогчдын хэлсэн санал дээр үндэслэн сургагч багш хичээлийн дараагийн алхам руу шилжиж, дэлгэц дээрх слайд руу анхаарлыг хандуулна.

Үйл ажиллагаа 2: Үндсэн хэсэг - 30 минут

Сургагч багш тусгайлан бэлтгэсэн “Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах” слайдыг танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Багийн ажил - 45 минут

Сургагч багш оролцогчдыг 5-6 багт хуваарилж, баг тус бүр “Сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа”- ны зураглал хийх даалгавар өгнө.

- Оролцогчид баг дотроо өөр өөрсдийн сургуулийн хүүхэд хамгааллын асуудлыг мэдээлж, хариу арга хэмжээ авах үйл явцаа танилцуулна. (5 минут).
- Бүх оролцогчдын саналыг сонссоны дараа багаараа тарааж өгсөн кейсд чиглэсэн (Хавсралт 1) хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зураглалыг боловсруулна. (15 минут).
- Багийн ажлаа бусад багуудад танилцуулахдаа өртөөчилсөн хэлбэрээр зохион байгуулна: (15 минут)
 - Багийн 2 гишүүн ширээн дээр үлдэнэ. Үлдсэн гишүүд нь бусад багийн ажлыг сонсож, тэмдэглэл хөтөлж ирнэ. Тэмдэглэл хөтлөхдөө өөрийн багийн ажилтай ижил, ялгаатай талыг онцолж тэмдэглэнэ. Өртөөчилсөн хэлбэрээр бүх багийн ажлыг сонссоны дараа өөрийн багийн 2 гишүүнд бусад багийн ажлуудыг танилцуулна.
- Сургагч багш багуудаас дараах асуултыг асууж бүлгийн ажлыг дүгнэнэ: (10 минут)
 - Хүүхэд хамгааллын асуудлыг хэн мэдээлдэг бэ?
 - Хүүхэд хамгааллын мэдээллийн хэн шилжүүлдэг вэ?

- Хүүхэд хамгааллын мэдээлэлд хэн хариу арга хэмжээ авдаг вэ?
- Сургууль

Үйл ажиллагаа 4: Дүгнэлт хэсэг - 10 минут

Сургагч багш дээрх бүлгийн дүгнэлтээ үргэлжлүүлэн хичээлийн холбогдох слайдыг дэлгэцнээ гаргаж дараах ойлголтыг тэмдэглэн хэлнэ:


- Сургууль нь хүүхэд хамгааллын үйл ажиллагааны журамтай байна.
- Энэхүү журамд мэдээлэх, мэдээлэл шилжүүлэх, мэдээлэлд хариу арга хэмжээ авах талаар заавал тусгагдсан байна.
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны журмыг сургуулийн хүүхэд хамгааллын баг, сургуулийн бүх багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд мэргэжлийн байгууллага зэрэг оролцогч талууд хамтран хэрэгжүүлнэ.

Н охин нь нийслэлийн нэгэн сургуулийн 9-р ангид сурдаг, 15 настай. Тэрээр ээж, ахын хамт амьдардаг бөгөөд аав нь архины хамааралтай учир 1 жилийн өмнөөс гэр бүлээсээ тусдаа амьдрах болсон. Аав нь үе үе сургуулийн орчимд согтуудаа ирдэг тул охин ихэд ичих, найз нөхдөөсөө зугтах болсон. Ангийн хүүхдүүд “аав чинь согтуу ирсэн байна” гэх мэтээр шоолон ярьдаг нь охинд сэтгэлзүйн хүчтэй дарамт үүсгэдэг.

Одоогоор охин ээж, ах хоёртойгоо хамт амьдардаг боловч ах нь уул уурхайн компанид 14 хоногийн хугацаатайгаар хөдөө ажилладаг. Иймээс ахтайгаа байнга хамт байдаггүй, зөвхөн сардаа нэг удаа харилцдаг. Ээж нь худалдааны байгууллагад нярав хийдэг бөгөөд өглөө эрт гэрээс гарч, орой их оройтож ирдэг. Ээж нь гэр бүлээсээ ганцаараа ажилладаг, завгүй байдаг тул охиндоо хангалттай цаг гаргадаггүй. Түүний хичээл сургуулийн асуудалд төдийлөн анхаарал тавьдаггүй. Заримдаа охинтойгоо маргалдаж, “чи миний үгийг сонсохоо больсон” хэмээн бухимдаж зөрчилддөг.

Н охин ихэнхдээ гэртээ ганцаараа үлддэг тул гэрийн орчинд хараа хяналт сул, гадуур цаг заваа өнгөрөөх нь олширсон. Сүүлийн саруудад шилжин ирсэн нэгэн охинтой ойр дотно найзалж, түүнтэй хамт гадуур удаан хугацаагаар тэнэж, гэрийн даалгавраа хийхээ больж, заримдаа хичээлээ таслах болсон. Багш нь энэ байдлыг анзаарч ээжид нь хэлсэн боловч ээж нь “ах нь удахгүй ажил дээрээсээ ирнэ, ах нь дүүтэйгээ яриад асуудлыг шийднэ” гэж хариулсан байна.

ЕБС-ийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны тойм



Нэмж судлах материалууд

- Боловсрол, шинжлэх ухааны яам. (2023). Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам. Улаанбаатар: БШУЯ.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=13346>
- Боловсрол, шинжлэх ухааны яам. (2023). Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам. Улаанбаатар: БШУЯ
<https://moe.gov.mn/post/125928>
- Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2024). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140463602711>
- Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль. (2016, 2021, 2024). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11709>
- Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль. (2023). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>
- Монгол Улсын Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. (2008, 2023). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга (2021). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>
- Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. (1999, 2022). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=226>
- Монгол Улсын Эрүүгийн хууль. (2015, 2017, 2023). Улаанбаатар: Улсын Их Хурал.
<https://legalinfo.mn/mn/detail/11634>
- ХИС (2023) Сургуульд баримтлах ёс зүйн дүрэм: Хүүхдэд ээлтэй сургалтын орчныг хэрхэн бүрдүүлэх вэ?. Хичээл 3. Сургууль дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн сайн сайхан байдал, хуудас 58-101, Хичээл 4. Хүчирхийллээс ангид сургууль, хуудас 108-152 Улаанбаатар.
- ХИС (2024). Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны загвар. Бүлэг 1. Сургууль, дотуур байрын орчин дахь хүүхэд хамгаалал, хуудас 12-40, Бүлэг 2. Сургууль, дотуур байрын орчин дахь удирдлага, багш ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, хуудас 42-54. Улаанбаатар.
- О.Мягмар, Б.Туяа, Х.Өлзийтунгалаг, Т.Цэндсүрэн (2020) Хүмүүжлийн эерэг арга: ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан гарын авлага. Улаанбаатар: Мөнхийн үсэг

Цахим контентууд

- ДЗОУМБ, Хүүхэд хамгаалал.
<https://www.youtube.com/watch?v=BEm35XCFw0w>
- НҮБХС, Хүүхдийн эсрэг бие махбодийн хүчирхийлэл, мэдээлэх.
<https://www.youtube.com/watch?v=d5dCN66PokQ>
- ХИС, Хүүхдийг зодож шийтгэхгүй байя.
https://www.youtube.com/watch?v=p_lVd9FUuc
- Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага.
<https://www.youtube.com/watch?v=BEm35XCFw0w>



Save the Children

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361

✉ mongolia.secretary@savethechildren.org
🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN 📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)